3 дах болон 7 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан дээр “Бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матриц” нь холбогдох олон тооны байгууллагаас бүрдсэн Х/Т-АХ-ийн оролцоотойгоор хэрэгжсэн тус төслийн хувьд гарах үр дүн, төслийн зорилгыг биелүүлж, төсөл дууссаны дараах холбогдох байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангаж бүрдүүлэх явдлыг зорилгоо болгосон юм. Матрицыг ерөнхийд нь ” 1. Төслөөс гарах үр дүнгийн бие дааж тогтвортой хөгжих хүчин зүйлийг тодорхойлох матриц” болон ” 2.Төслийн үр дүнд хамаарах Х/Т-АХ-ийн холбогдох байгууллагын ажлын хувиарлалт, үүрэг оролцооны хэлбэрийг судлах матриц” гэж хуваасан.

Эхний матрицын хувьд үр дүн болон төслийн зорилгод хүрэхэд чиглэсэн шат дарааллыг техникийн ур чадавхи эзэмшүүлсэн боловсон хүчнээр хангах, ур чадавхийг бэхжүүлж сайжруулах, түүнийг ашиглах байдлыг хангах, тоног төхөөрөмж болон байгууламж зэрэг ажиллах орчныг бүрдүүлэх, тэдгээрийн ашиглалтын хяналт, мэдээллийн сан суурыг бүрдүүлж, ашиглалтанд хяналт тавих, ажлын гүйцэтгэл, чанарын хяналт, байгууллагыг боловсон хүчнээр хангах, төсөв бүрдүүлэлт, байгууллагын бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлэх, байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, АБ-ын эсрэг авах арга хэмжээг сонгон шийдвэрлэх, мөн хэрэгжүүлэх механизмыг бий болгох гэсэн хүчин зүйлүүдийн хүрээнд авч үзсэн.

2 дах матрицын хувьд үр дүн болон төслийн зорилгыг биелүүлэхэд чиглэсэн холбогдох байгууллага хоорондын ажлын хувиарлалт, үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд авч үзсэн юм.

Мөн 3 дах удаагийн ХЗХ-ны хуралдааны үеэр авч хэлэлцсэн “Бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матриц”-ыг Хавсралт материал 1.4-2-д, 7 дах удаагийн хуралдааны үеэр хэлэлцэж яригдсан матрицын агуулгыг Хавсралт материал 1.4-3-д тус тус үзүүлэв.

Хүснэгт 1.4-1 ХЗХ-ны хуралдааны тэмдэглэл

Хурал, семинар, ажил хэргийн хуралдаан болон сургалтын нэр	Явагдсан огноо	Гол агуулга
1 дэх ХЗХ-ны хуралдаан	2010.04.15	Судалгааны тайлангийн танилцуулга, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Х/Т-АХ-ийн гишүүд болон оролцогчдын жагсаалтыг баталсан. Мөн удахгүй японд зохион байгуулахаар төлөвлөж байсан утааны хийн хэмжилтийн сургалтанд хамрагдах хүмүүсийг сонгон шалгаруулах зааварчилгааг нарийвчлан гаргаж шийдвэрлэсэн.
2 дах ХЗХ-ны хуралдаан	2011.01.05	Явцын тайлан-1-ыг баталсан. ТТМ-д агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хувилбарын тоог 20 гэж тогтоосон. . Мөн монгол тал нь тархалтын загварчлалыг ихээхэн сонирхож, ДЦС зэрэгт авах арга хэмжээг судалхад чухал үүрэг гүйцэтгэх утааны хийн хэмжилтийн дүнг холбогдох байгууллага хүмүүст гаргаж өгөхийг хүссэн.
3 дах ХЗХ-ны хуралдаан	2011.09.23	Явцын тайлан-2-ыг баталсан. Зуухын бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явагдсан. Япон мэргэжилтний хувьд ДЦС-тай орчны бохирдлоос хамгаалах тухай хэлэлцээр байгуулж, хяналт тавьж ажиллахыг зөвлөсөн. Монгол тал нь УХЗ-ыг төвлөрсөн системд оруулах санал тавьсан бөгөөд мэргэжилтний зүгээс ч энэ арга хэмжээг дэмжиж санал нийлсэн. ЖАЙКА байгууллагын мэргэжилтэн нь монгол талд хандан ДЦС 2 болон 3 нь цаашид оршин тогтнох эсвэл хаагдах талаар тодорхой байр сууриа илэрхийлэх нь зүйтэй гэж онцлон тэмдэглэсэн. Төслийн үр дүнгийн цаашид бие дааж тогтвортой хөгжих нөхцлийг хангах матрицын талаар тайлбарлаж, хэлэлцүүлэг явагдсан. ХЗХ-ны дарга дэлгэрэнгүй нарийвчилсан матрицын дагуу хийгдсэн дүн шинжилгээг сайшааж, монгол талын холбогдох байгууллага, албаны хүмүүсийг энэ тал дээр анхаарч, зохих бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт хийхийг уриалсан.
4 дэх ХЗХ-ны хуралдаан	2011.12.02	Явцын үнэлгээний дүнгийн тайланг баталгаажуулсан. Зуухны бүртгэл хяналтын тогтолцооны явцын байдлыг тайлагнасан. Бусад хандивлагч байгууллагууд хэрэгжүүлээгүй байсан УХЗ-ны утааны хийн хэмжилтийн дүн, шинжлэх ухааны үндэслэлтэй өгөгдлийг олж чадсаныг чухал

		<p>ач холбогдолтой гэж хамтарсан үнэлгээний багаас үнэлж, онцлон тэмдэглэсэн.</p> <p>Дэлхийн банкны семинарт утааны хийн хэмжилтийн дүнгийн талаар илтгэл тавьсан бөгөөд ЭХЯ-ны мэргэжилтнээс тус хэмжилтийн дүнг хэвлэл мэдээллээр нийтэд мэдээллэх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байсан.</p>
5 дах ХЗХ-ны хуралдаан	2012.10.22	<p>Явцын тайлан-3-ыг баталсан. .</p> <p>ЦУОШГ-ын төсөлд оролцогч гишүүнээс РМ10-ын тархалтын загварчлалын дүн нь суурин харуулын хэмжилтийн дүнтэй зөрүүтэй байгааг учир шалтгааныг талаар асуулт тавьж, энэ талаар тархалтын загварчлалыг хариуцсан төслийн япон мэргэжилтэн байж болох магадлалын талаар тайлбарласа.</p>
6 дах ХЗХ-ны хуралдаан	2012.12.07	<p>Эцсийн шатны үнэлгээний дүнгийн тайланг баталсан. Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний саналын танилцуулга, хэлэлцүүлэг явагдсан.</p> <p>ЖАЙКА-ын төв албаны ажилтан нь АБ-ын эсрэг авах арга хэмжээний талаар Х/Т болон Х/Т-АХ-ийн хүрээнд хэлэлцүүлэг явуулж, хотын орлогч дарга болон АББҮХ-нд танилцуулах ажил хийхийг хүссэн. Мөн монгол талаас төслийн II үе шатыг хэрэгжүүлэх талаар хүсэлт тавьж, өмнө хэрэгжиж эхлээд байгаа Дэлхийн банкны төсөл болон тус төслөөс харилцан уялдуулсан үр дүнг гаргах талаар зохицуулж ажиллах бодолтой байгаа талаар ярьсан.</p>
7 дах ХЗХ-ны хуралдаан	2013.02	<p>Төслийн эцсийн тайлангийн саналын танилцуулга, хэлэлцүүлгийг явуулж, энэ талаарх санал бодлоо гаргах хугацааг зааж өгсөн. Мөн төсөл дуусаж байгаатай холбогдуулан төслийн мэргэжилтний зүгээс цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудлын талаар илтгэл тавьсан. Хуралдааны төгсгөлд олон улсын хамтын ажиллагааны мэргэжилтэнээс цаашдын үйл ажиллагааны зохион байгуулалт, төсөл болон тэдгээрийг хамруулсан нөхцөл байдлын талаар санал бодлоо илэрхийлсэн.</p>

1.5 Төслийн тайлангийн тэмдэглэл

Хүснэгт 1.5-1-т төслийн тайлан гарсан болон батлагдсан хугацааг үзүүлэв.

Хүснэгт 1.5-1 Төслийн тайлангийн тэмдэглэл

Тайлангийн нэр	Гаргасан хугацаа	Батлагдсан хугацаа
Судалгааны тайлан	2010 оны 4 сар	2010 оны 5 сар
Явцын тайлан-1	2010 оны 12 сар	2011 оны 1 сар (2 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Явцын тайлан-2	2011 оны 6 сар	2011 оны 9 сар (3 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Явцын тайлан-3	2012 оны 6 сар	2012 оны 10 сар (5 дах удаагийн ХЗХ-ны хуралдаан)
Эцсийн тайлангийн төсөл Техникийн гарын авлагын санал	2013 оны 1 сар	2013 оны 2 сар
Эцсийн тайлан Техникийн гарын авлага	2013 оны 3 сар	-

1.6 Техникийн гарын авлага болон ажиллагааны зааварчилгаа

Төслийн хүрээнд боловсруулж гаргасан техникийн гарын авлагыг Хүснэгт 1.6-1-т үзүүлэв. Тус төсөлд техникийн ур чадавхийн талаар тайлбарласан агуулга бүхий материалыг “Гарын авлага”, ажиллах горим зарчмын талаар тайлбарласан материалыг “Ажиллагааны зааварчилгаа” гэж нэрлэсэн болно. Гарын авлагыг тусгайлан хэвлэж, тараасан.

Хүснэгт 1.6-1 Техникийн гарын авлагын жагсаалт

Салбар, чиглэл	Гарын авлагын нэр
Утааны хийн хэмжилт	Утааны хийн хэмжилтийн стандарт, горим Утааны хийн хэмжилтийн үндсэн зарчим, голлох хэмжилтийн утгыг хэрхэн авч үзэх, параметр тус бүрийн тооцооллын арга зэрэг хэмжилтийн үндсэн аргачлалын онолын талаар тайлбарласан болно.
	Сорьцын цэгийг суурилуулах зааварчилгаа Төслийн хүрээнд утааны хийн хэмжилт хийхийн тулд зуухны яндан болон утааны сувагт хэмжилтийн сорьцын цэгийг суурилуулах шаардлага болон түүнийг суурилуулах арга (холбогдох зураг схемьг оруулан)-ын талаар тайлбарласан.
	Утааны хийн химийн анализ шинжилгээний дээж авалт, анализ шинжилгээний зааварчилгаа Уусмалын аргаар агаар бохирдуулах бодисын агууламжийг хэмжих зорилгоор дээж авах арга болон авсан дээжийг лабораторт шинжилж, анализ хийх аргын талаар тайлбарласан.
	ДЦС-ын утааны хийн хэмжилтийн зааварчилгаа ДЦС-т утааны хийн хэмжилтийн стандарт, үндсэн горимын дагуу ажиллах талаар дэлгэрэнгүй тайлбарласа.
	УХЗ, гэрийн зуухны утааны хийн хэмжилтийн зааварчилгаа УХЗ болон гэрийн зууханд утааны хийн хэмжилт хийх стандарт, үндсэн горимын дагуу ажиллах талаар дэлгэрэнгүй тайлбарласан.
Зуухны бүртгэл хяналт	Зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны гарын авлага Тус тогтолцооны танилцуулга, зуухны бүртгэлийн маягтын агуулга, мэдээллийн сангийн функцийн талаар тайлбарласан.
Эх үүсвэрийн инвентор	Эх үүсвэрийн инвенторыг боловсруулах, шинэчлэх гарын авлага Эх үүсвэрийн инвентор гэдэг ухагдахуунаас эхлээд УБ хотын эх үүсвэрийн инвенторын тодорхой байдал, агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээний тооцооллын аргын талаар тайлбарласан.
Тархалтын загварчлал	Тархалтын загварчлалыг боловсруулж, шинэчлэх гарын авлага Тархалтын загварчлалын моделийг гаргах, түүний үүрэг функцийн талаар тайлбарлахын зэрэгцээ УБ хотын хэмжээнд боловсруулж гаргасан тархалтын загварчлалын дүнг танилцуулсан.

2 Үйл ажиллагааны товч танилцуулга

2.1 Агаар бохирдуулах эх үүсвэрийн дүн шинжилгээ, агаар орчны үнэлгээний чадавхийг бий болгох (Үр дүн 1)

2.1.1 Үр дүн 1-тэй холбоотой техникийн үр чадавхи эзэмшүүлэлт (семинар, ажил хэргийн хуралдаан зэргийг багтаах)

2.1.1.1 Зуухны бүртгэл, зөвшөөрөл олгох тогтолцоо болон эх үүсвэрийн инвентортой холбоотой ажил хэргийн хуралдаан (2010 оны 6 сарын 25 өдөр)

Япон болон Монголд зуухны бүртгэл, зуух ашиглах зөвшөөрөл олгох тогтолцоо болон эх үүсвэрийн инвенторын талаар ажил хэргийн хуралдааныг зохион байгуулсан. Монгол тал нь эх үүсвэрийн инвентор болон зуухны бүртгэлийн тогтолцооны харилцан уялдаа холбооны талаар хангалттай ойлголцогүй байсан тул ажил хэргийн хуралдаан зохион байгуулах зэргээр энэ чиглэлээр ойлголт, мэдлэг өгөх тал дээр ажиллаж энэ нь техникийн үр чадавхи эзэмшүүлэх үйл ажиллагаатай уялдан хэрэгжсэн болно.

2010 оны 6 сарын 25 өдөр явагдсан ажил хэргийн хуралдааны материалыг Хавсралт материал 2.1-1-т үзүүлэв.

Явагдсан огноо : 2010 оны 6 сарын 25-ны өдөр (Баасан) 10:00~14:05

Явагдсан газар : Puma Imperial Hotel

1. Нээлт

10:00-10:05 Openings by Chultemsuren BATSAIKHAN, AQDCC

2. Зуухны бүртгэл, ашиглах зөвшөөрлийн тогтолцоо

10:05-10:25 Presentation on boiler registration system in Japan by Mr. Masanori EBIHARA (Boiler Technology for Air Pollution Control 2)

10:25-10:45 Presentation on boiler registration in Mongolia Mr. Ts. MUNKHBAT (Ministry of Nature, Environment and Tourism, Office of Environmental Pollution)

10:45-11:45 Discussions on Boiler Registration and Permission System

11:45-12:00 Coffee Break

3. Эх үүсвэрийн инвентор

12:00-12:20 Presentation on stationary source inventory in Japan by Mr. Toru TABATA (Stationary Source Inventory / Simulation 1)

12:20-12:40 Presentation on mobile source inventory in Japan by Mr. Hiroyuki MAEDA (Mobile Source Inventory)

12:40-13:00 Presentation on emission source inventory in Mongolia by Ms. Sarangerel ENKHMAA (National Agency for Meteorology and Environment Monitoring)

2.1.1.2 Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын тухай ажил хэргийн хуралдаан (2011 оны 3 сарын 4 өдөр)

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалыг гаргах тухай ажил хэргийн хуралдааныг зохион байгуулсан бөгөөд энэ үеэр 2011 оны 2 сарын байдлаарх УБ хотын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэр, тархалтын загварчлалын дүнг тайлагнаж, холбогдох салбарын байгууллагуудтай мэдээллээ хуваалцаж, санал бодлоо солилцсон.

2011 оны 3 сарын 4 өдөр зохион байгуулагдсан хуралдааны материалыг Хавсралт материал 2.1-2-т үзүүлэв.

Огноо : 2011 оны 3 сарын 4 өдөр (Баасан) 10:00-13:00

Газар : Монгол-Японы төв

Хөтөлбөр

10:00~10:05 Нээлт (НАЧА)

10:05~10:25 Эх үүсвэрийн инвентор гэдэг нь? (Табата)

10:25~10:55 Суурин эх үүсвэрийн инвенторын талаар (Табата)

10:55~11:20 Хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэрийн инвентор, агаар бохирдуулах бодисын нийт ялгарлын хэмжээний талаар (Маэда)

11:20~11:35 Тархалтын загварчлалын дүнгийн талаар (Табата)

11:35~11:50 Үдийн завсарлага

11:50~12:50 Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын талаарх хэлэлцүүлэг

12:50~12:55 Дүгнэлт

12:55~13:00 Хаалт

2.1.1.3 Инвентор, тархалтын загварчлалын тухай сургалт (2 дах жилийн)

Инвентор, тархалтын загварчлалын сургалтыг ЦУОШГ-ын сургалтын танхимд Хүснэгт 2.1-1-т үзүүлсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Сургалтанд 15 хүн оролцсон бөгөөд тархалтын загварчлалын моделийг боловсруулж гаргахын тулд цаг уурын өгөгдөл болон агаар орчны өгөгдөл дүн шинжилгээ хийх, модельд оруулах өгөгдлийг боловсруулах арга, моделийн дүнгийн үнэлгээний аргын талаар голчлон зааж, оролцогчдод инвенторын өгөгдлийн шинэчлэл, тархалтын загварчлалын моделийг дахин боловсруулахад шаардагдах техникийн ур чадавхи болон ноу-хаут эзэмшүүлсэн. Инвентор, тархалтын загварчлалын сургалтын байдлыг Зураг 2.1-1-т үзүүлэв. Тус сургалтанд ашигласан

материалыг Хавсралт материал 2.1-3-т үзүүлэв.

Хүснэгт 2.1-1 Сургалтын агуулга болон хөтөлбөр

Огноо	Суурин эх үүсвэр	Хөдөлгөөнт болон бусад эх үүсвэр	Тархалтын загварчлал
Эхний удаа 2011/6/6 (Даваа) 10:00~14:00	Гэрийн зуух, ханын пийшингийн ялгарлын хэмжээний тооцоолол	Автомашини Я/К-д нөлөөлөх гол хүчин зүйл	Цаг уурын болон агаар орчны өгөгдлийн дүн шинжилгээ
2 дах удаа 2011/6/7 (Мяг) 10:00~14:00	Бага оврын УХЗ-ны ялгарлын хэмжээний тооцоолол	Автомашини Я/К	Тархалтын загварчлалын моделийг боловсруулах
	Зуухны бүртгэлийн өгөгдлийг ашигласан ДЦС, УХЗ, үйлдвэрийн ялгарлын хэмжээний тооцоолол, даалгавар	Автомашини хөдөлгөөний эрчим, зорчих хурд, Я/К-ийг ашигласан ялгарлын хэмжээний тооцоолол, даалгавар	Моделийн оруулалтын өгөгдлийг боловсруулах, суурилуулах
3 дах удаа 2011/6/15 (Лха) 14:00~16:00	Ялгарлын хэмжээний тооцооллын нарийвчлал, ялгарлын хэмжээний нийлбэр, даалгаврын хариу тулгах		Тархалтын загварчлалын моделийн үндсэн ажиллагааг суралцах, боловсруулах
4 дэх удаа 2011/6/23 (Пүр) 10:00~12:00		Бусад эх үүсвэр	



Зураг 2.1-1 Инвентор, тархалтын загварчлалын сургалт

2.1.1.4 Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын тухай ажил хэргийн хуралдаан (2011 оны 6 сарын 13 өдөр)

Эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын талаар сургалт, ажил хэргийн хуралдааныг зохион байгуулсан бөгөөд тус хуралдааны үеэр 2011 оны 3 сар хүртэлх судалгааны дүнд тулгуурлан УБ хотын суурин болон хөдөлгөөнт эх үүсвэр, мөн бусад эх үүсвэр, тархалтын загварчлалын дүнгийн талаар илтгэл тавьсан. Оролцогчид нь тус сургалтаар дамжуулан тархалтын загварчлалын моделийн нарийвчлалыг сайжруулахад мониторингийн өгөгдөл, эх үүсвэрийн инвентор болон тархалтын моделийг цогцоор нь сайжруулах, дутагдалтай байгаа эх үүсвэрийн инвенторыг шинээр боловсруулах шаардлагатай байдаг зэргийн талаар ойлгож мэдсэн. Мөн нарийвчлалыг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаанд ямар зүйл чухал шаардлагатай болох талаар хэлэлцүүлэг маргаан явагдсан.

Э дгээр маргаан хэлэлцүүлэгт тулгуурлан өгөгдлийн нарийвчлалыг сайжруулахад шаардлагатай өвлийн улирлын иж бүрэн судалгааг төлөвлөж хэрэгжүүлсэн.

2011 оны 6 сарын 13 өдөр зохион байгуулагдсан ажил хэргийн хуралдааны материалыг Хавсралт материал 2.1-4-т үзүүлэв.

Огноо	: 2011 оны 6 сарын 13 өдөр (Даваа) 10:00-13:00
Газар	: Монгол Японы төв 2 давхар
10:00~10:05	Нээлт (НАЧА)
10:05~10:35	Суурин эх үүсвэрийн инвенторын талаар (Табата : Суурин эх үүсвэрийн инвентор/Тархалтын загварчлал-1)
10:35~11:05	Хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэрийн инвенторын талаар (Маэда : Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор)
11:05~11:20	Агаар бохирдуулах бодисын нийт ялгарлын хэмжээ болон инвентор өгөгдлийн нарийвчлалын талаар (Табата)
11:20~11:35	Инвентор өгөгдлийн нарийвчлалыг сайжруулахад чиглэсэн цаашдын үйл ажиллагааны талаар (НАЧА)
11:35~11:50	Үдийн завсарлага
11:50~12:05	Тархалтын загварчлалын дүнгийн талаар (Табата)
12:05~12:25	Инвентор, тархалтын загварчлалыг боловсруулах бүтэц тогтолцооны талаар (ЦУОШГ)
12:25~12:50	Инвентор болон тархалтын загварчлалын талаарх хэлэлцүүлэг

Зуухын бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан япон монголын зуухны бүртгэлийн тогтолцоо болон ялгарлын инвенторийн талаар тайлбарлаж, зуухны бүртгэлийн тогтолцоог ашигласан эх үүсвэрийн инвенторыг боловсруулах аргын талаар харилцан ойлголтоо гүнзгийрүүлсэн.

2.1.1.5 ЖАЙКА –ын бүс нутгийн сургалтын follow-up семинарийн илтгэл

2012 оны 3 сарын 6 өдөр ЖАЙКА-ын бүс нутгийн сургалт “ Хотын автомашинаас үүдэлтэй орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ” сургалтын follow-up семинарыг УБ хотын Кемпинский зочид буудалд зохион байгуулагдсан бөгөөд тус семинарт 53 орчим хүн оролцсон юм.

Тус семинарт УБ хотын хөдөлгөөнт эх үүсвэрийн талаар илтгэл тавьсан бөгөөд автомашинаас үүдэлтэй бохирдуулалтын агаарын чанарын стандартаас хэтэрсэн байдал, ялгарлын хэмжээ, агаар бохирдуулах бодисны ялгарлыг багасгах арга зэрэг хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор болон түүнтэй холбоотой мэдээллийн талаар тайлбарлаж танилцуулсан.

Тарааж ашигласан материалыг Хавсралт материал 2.1-5-т үзүүлэв. Мөн НАЧА-ны цахим хуудас тавигдсан байгаа.

<http://www.airquality.ub.gov.mn/index.php/en/2011-05-26-08-29-50/2012-03-23-01-08-58.html>



Зураг 2.1-2 "Автомашинаас үүдэлтэй орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ" сургалтын follow-up семинар

Эх сурвалж: ЖАЙКА төслийн баг



Зураг 2.1-3 НАЧА-ны цахим хуудас

2.1.1.6 Х/Т-АХ-ийн уулзалт хуралдаан дахь танилцуулга

2012 оны 3 сарын 29 өдрийн Х/Т-АХ-ийн хуралдааны үеэр суурь оны эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын дүнгийн талаар танилцуулж, хэлэлцүүлэг явуулсан бөгөөд төсөл дууссанаас хойших байдлыг бодоод гарах үр дүн тус бүрийн хувьд цаашид хамтран ажиллах тогтолцооны талаар хэлэлцсэн. Холбогдох материалыг Хавсралт материал 2.1-6-д үзүүлэв.

Хэлэлцүүлгийн гол агуулга:

- 1) Агаар орчны хэмжилтийн цэг дэх хэмжилтийн утгатай тархалтын загварчлалаар гаргасан агаар бохирдуулах бодисын агууламж их зөрүүтэй байгааг учир шалтгааны талаар
- 2) Инвентор боловсруулах ажлыг НАЧА, УАЧМА, ЦУОШГ хийх бөгөөд эдгээр 3 байгууллагаас гадна ямар байгууллага ямар ажилд нь оролцож, хамтран ажиллах нь зүйтэй вэ гэдэг нь инвенторыг боловсруулж, тархалтын загварчлал гаргах ажлыг хийх явцад тодорхой болох тул цаашид тухайн үеийн байдлаас харан нарийн тодорхой саналыг боловсруулж, холбогдох хэлэлцүүлгийг хийсний үндсэн дээр шийдвэрлэх юм.

2.1.1.7 Үнсний цацраг идэвхийн шинжилгээний нарийвчлалын магадлагаа

Монгол улсын нүүрсний шатсан үнсэнд цацраг идэвхт бодис агуулагддаг тул анхаарах шаардлагатай байдаг бөгөөд дахин ашиглахтай холбогдуулан үнсэнд агуулагдах цацраг идэвхт бодисын түвшингээр стандарт тогтоосон байдаг. Тус төслийн хүрээнд үнсний цацраг идэвхийн шинжилгээг адилхан нэг дээжнээс японы итгэмжлэгдсэн найдвартай шинжилгээний байгууллагаар хийлгэсэн шинжилгээний дүнг монголд хийсэн шинжилгээний дүнтэй харьцуулан шинжилгээний нарийвчлалыг магадласан юм.

МУ-ын Их сургууль болон японы шинжилгээний төвийн хийсэн шинжилгээний дүнг ашиглан нарийвчилсан харьцуулалт шалгалт хийхийн зэрэгцээ японы шинжилгээний төвийн мэргэжилтэн МУИС-д зочлон ирж, шинжилгээний байдалтай танилцаж, тус шинжилгээний дүнгийн зохистой зөв байдал болон шинжилгээний ар барил, ашиглаж буй технологийг үзэж баталгаажуулсан болно.

МУИС-д байнгын хэмжилтийн цагийг 7200 секунд гэж авдаг бөгөөд ^{235}U (144keV) -ын гаргалт хийхэд бэрхшээлтэй байгаа тул ^{226}Ra -аар хэмжилтийн дүнд зөрүү гарсан хэдий ч өнөөгийн нөхцөл байдалд одоо хэмжилтэнд ашиглаж буй тоон үзүүлэлтээр тодорхойлох аргыг хэрэглэхээс өөр аргагүй байгаа гэж үзсэн. (Хавсралт материал 2.1-7)

2.1.1.8 Инвентор, тархалтын загварчлалын тухай сургалт (3 дах жилийн)

ЦУОШГ-ын сургалтын танхимд инвентор, тархалтын загварчлалын сургалтыг зохион байгуулсан бөгөөд сургалтын товч агуулга, хөтөлбөрийг Хүснэгт 2.1-2 боло Хүснэгт 2.1-3-т үзүүлэв. Сургалтанд 9 хүн оролцсон бөгөөд эх үүсвэрийн инвенторын бүтэц, шинэчлэх арга, тархалтын загварчлалын моделийг боловсруулж гаргахад шаардагдах цаг уурын өгөгдөл болон агаар орчны өгөгдлийн дүн шинжилгээ, модельд оруулах өгөгдлийг боловсруулах арга, GIS soft-ыг ашигласан тархалтын зургийг гаргах арга зэргийг голчлон анхаарч заасан болно. Сургалтанд оролцогчдод инвенторын өгөгдлийн шинэчлэл, тархалтын загварчлалын моделийг дахин боловсруулж гаргахад шаардагдах техникийн ур чадавхи, ноу-хауг эзэмшүүлсэн. Инвентор, тархалтын загварчлалын сургалтын байдлыг Зураг 2.1-4-т үзүүлэв.

Мөн 2 өдөр зохион байгуулагдсан сургалтаар мэдэж авсан мэдлэг, дадлагыг баталгаажуулж гүнзгийрүүлэхийн тулд эх үүсвэрийн инвенторыг шинэчлэх арга, модельд оруулах өгөгдлийг боловсруулах арга, моделийн дүнгийн үнэлгээний арга зэргийг чухалчлан үзэж, 2012 оны 9 сарын 25 болон 11 сарын 6 өдөр ур чадавхи эзэмшүүлэх давтлага, дадлага голлосон сургалтыг зохион байгуулсан. Тархалтын загварчлалыг боловсруулахад эх үүсвэрийн цагийн өөрчлөлт, сар тутмын өөрчлөлт, параметрийн зохицуулалт зэрэг өмнөх сургалтаар заагдаагүй ур чадавхийн талаар тусгайлан заасанаар оролцогчид энэ талаар зохих мэдлэг, ур чадавхийг эзэмшсэн. Сургалтын материалыг Хавсралт материал 2.1-8-д үзүүлэв. Мөн сургалтын тараах материалд тулгуурлан “Эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын техникийн гарын авлага”-ыг боловсруулж гаргасан. (Хавсралт материал 2.1-9)

Хүснэгт 2.1-2 Сургалтын товч агуулга

Явагдсан огноо	2012 оны 9 сарын 14 өдөр (Баасан) 9:30-17:30 2012 оны 9 сарын 17 өдөр (Даваа) 9:30-17:45 2012 оны 9 сарын 25 өдөр (Мягмар) 13:30~16:15 2012 оны 11 сарын 6 өдөр (Мягмар) 10:30~12:15
Газар	ЦУОШГ-ын сургалтын танхим
Оролцогч	(НАЧА) Даваажаргал, Галымбек, Цацрал (ЦУОШГ) Энхмаа (УАЧМА) Нямдаваа, Өнөрбат, Баярмагнай (УЦУОХ) Гансүх (БОХТЛ) Бархасрагчаа

Хүснэгт 2.1-3 Сургалтын хөтөлбөр

9/14 (Баасан)	Ерөнхий тайлбар (Табата)	
	9:30~10:30	Эх үүсвэрийн инвентор боловсруулахаас тархалтын загварчлалын модель гаргах хүртэлх ажиллагааны дараалал
	Эх үүсвэрийн инвенторыг боловсруулах арга (Наката)	
	10:45~12:00	ArcGIS-ыг ашигласан ялгарлын хэмжээний тархалтын зургийг гаргах аргын талаарх тайлбар
		ДЦС-ын ялгарлын хэмжээний инвенторын тайлбар
	12:00~13:00	Үдийн завсарлага
13:00~17:30 (дундаа завсарлагатай)	ДЦС-ын ялгарлын хэмжээний инвенторыг шинэчлэх аргын тайлбар болон дадлага ажил, ялгарлын хэмжээний тархалтын зургийг боловсруулж гаргах	
	Бага оврын УХЗ-ны ялгарлын хэмжээний инвенторын тайлбар	
	Бага оврын УХЗ-ны ялгарлын хэмжээний инвенторыг шинэчлэх аргын тайлбар болон дадлага ажил, ялгарлын хэмжээний зургийг боловсруулж гаргах	
9/17 (Даваа)	9:30~12:00 (дундаа завсарлагатай)	УХЗ-ны ялгарлын хэмжээний инвенторын тайлбар
		Гэрийн ялгарлын хэмжээний инвенторын тайлбар
		Гэрийн ялгарлын хэмжээний инвенторыг шинэчлэх аргын тайлбар болон дадлага ажил, ялгарлын хэмжээний тархалтын зургийг боловсруулж гаргах
	12:00~13:00	Үдийн завсарлага
	13:00~14:30 (дундаа завсарлагатай)	Хөдөлгөөнт эх үүсвэрийн ялгарлын хэмжээний инвенторын тайлбар, ялгарлын хэмжээний тархалтын зургийг боловсруулж гаргах.
		Бусад эх үүсвэрийн ялгарлын хэмжээний инвенторын тайлбар, ялгарлын хэмжээний тархалтын зургийг боловсруулж гаргах.
	Тархалтын загварчлалын модель боловсруулах (Наката)	
	14:45~17:30 (дундаа завсарлагатай)	Цаг уур, агаар орчны өгөгдлийн дүн шинжилгээ
Тархалтын загварчлалыг боловсруулах талаар тайлбар		
Модельд оруулах өгөгдлийг боловсруулах, суурилуулах		
Тархалтын загварчлалын моделийн үндсэн ажиллагааг суралцах		

		Тооцооллын агууламжийн дүнгийн тархалтын зургийн боловсруулж гаргах
	Сургалтын дараах даалгавар (Наката)	
	17:30~17:45	Шинэчилсэн суурин эх үүсвэрийн инвенторыг ашиглан SO ₂ -ын агууламжийн тархалтын загварчлал болон агууламжийн тархалтын зургийг боловсруулж гаргах

Сургалтанд оролцогчид нь Access болон ArcGIS программ дээр анх удаа ажиллаж үзсэн бөгөөд эхний үед хичээл дадлагын ахиц муу удаан байсан хэдий ч эдгээр программ дээр ажиллаж сургахын тулд ялгарлын инвенторын шинэчлэл болон ялгарлын тархалтын зургийг боловсруулж гаргах ажлыг голчлон хийлгэж дадлагажуулсан. Ингэснээр сургалт эхэлж байсан анхны үетэй харьцуулахад явах ахиц хурдан болж, сайн ойлгосон нэг нь ойлгож учраа олоогүй байгаа нөгөө нэгэндээ тусалж хамтран ажиллаж эхэлсэн.

Дараах хэсэгт тус сургалтын товч агуулгыг үзүүлэв.

(1) Ерөнхий танилцуулга, тайлбар

2011 оны 6 сард явагдсан сургалтын үеэр тайлбарласан байсан ч энэ удаагийн сургалтанд анх удаа оролцож байгаа хүмүүс байсан тул дахин давтах байдлаар инвентор, тархалтын загварчлалын талаар товч танилцуулж тайлбарласан.

(2) Эх үүсвэрийн инвенторыг боловсруулах арга

Суурин болон хөдөлгөөнт эх үүсвэр, мөн бусад эх үүсвэрийн ялгарлын хэмжээний инвенторыг боловсруулахад шаардлагатай үзүүлэлт, инвенторын боловсруулалт болон шинэчлэлийн аргын талаар тайлбарласан. Мөн инвентор файлыг Access уруу import хийх арга, цэгэн эх үүсвэрийн газарзүйн координатыг тодорхойлох болон датум хөрвүүлэлтийн аргын талаар тайлбарлаж дадлага ажил хийлгэсний дээр ялгарлын хэмжээний тархалтын зургийг боловсруулж гаргах аргыг тайлбарлаж мөн дадлага ажлыг хийлгэсэн.

(3) Тархалтын загварчлалын модель гаргах

Тархалтын загварчлалын модельд гаргахад шаардлагатай цаг уурын өгөгдлийн үзүүлэлтийг тайлбарлаж, салхины тархалтын зургийг боловсруулах дадлага ажил хийхээр төлөвлөж байсан хэдий ч ашиглаж буй сургалтын танхимын компьютерын Acrobat Reader-д япон хэлний фонт байгаагүй тул үзүүлж гаргах боломжгүй болсон тул дадлага ажлыг хийх боломжгүй болсон. Агаар орчны анализын аргын жишээ болгож цагийн хуваарь тус бүрээр дундаж агууламжийг Access дээр тооцооллох аргын талаар тайлбарлаж, Excel дээр цагийн хуваарь тус бүрээр дундаж агууламжийг зурж үзүүлэх ажиллагаа хүртэл дадлагыг хийсэн. Агууламжийн тархалтын загварчлалын модельд оруулах өгөгдлийг боловсруулах болон тооцооллын дүнгийн хэлбэрийг хувиргаж хөрвүүлэх аргыг тайлбарлаж, ДЦС-ын хувьд оруулах өгөгдлийн боловсруулах, тооцооллыг гүйцэтгэх, агууламжийн тархалтын зургийг гаргах талаар дадлага хийсэн.

(4) Сургалттай холбогдуулсан даалгавар

Сургалттай холбогдуулан дараах даалгаврыг өгсөн.

ДЦС, УХЗ, бага оврын УХЗ, гэр гэсэн эх үүсвэр тус бүр дээр сургалтын үеэр шинэчилсэн инвенторыг ашиглан SO₂-ын агууламжийн тархалтын загварчлалыг гаргах.

ArcGIS программ ашиглаж болох орчин байгаа эсэх, сургалтын агуулгыг ойлгосон байдал зэргээс хамааран 3 үе шаттайгаар даалгавраа ирүүлэхээр болсон.

ArcGIS ашиглах боломжгүй тохиолдол : Бүх эх үүсвэр тус бүрийн агууламжийн тооцооллын дүн (ArcGIS дээр ашиглах хэлбэрт оруулсан файл)

ArcGIS ашиглах боломжтой тохиолдол : боломжтой бол : эх үүсвэр тус бүрийг нийлүүлэн тооцоолсон агууламжийн тархалтын зураг

Хэцүү байгаа тохиолдол : Эх үүсвэр тус бүрийн агууламжийн тархалтын зураг



Зураг 2.1-4 Сургалт явагдаж буй байдал

2.1.1.9 Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын сургалт (3 дах жилийн)

Ялгарлын инвенторыг шинэчлэх заварчилгаа (санал) болон 2010 оны инвенторын тооцооллыг ашигласан Microsoft Access мэдээллийн сангийн файлыг сургалтанд ашиглан Microsoft Access программын үндсэн ашиглах арга, мэдээллийн сангийн хуримтлалын байдал, тооцооллын заварчилгаа зэргийг тайлбарласан. Сургалтын тараах материалыг Хавсралт материал 2.1-10-д үзүүлэв.

Сургалтын товч танилцуулгыг Хүснэгт 2.1-4 болон Хүснэгт 2.1-5-д, сургалтын байдлыг Зураг 2.1-5-д тус тус үзүүлэв.

Төсөлд хамтран ажиллагч талуудад тайлагнах, инвенторын шинэчлэлийг тогтмол хийж, түүнийг үр дүнтэй ашиглах зорилгоор хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторыг хариуцагч оролцогч талаас гадна бусад хамаарах мэргэжилтэнүүдийг урьж оролцуулсан бөгөөд БОХЗТЛ (2011 оны дизель хөдөлгүүрийн туршилтанд утааны хийн хэмжилтийг хариуцсан мэргэжилтэн), АББҮХ (автомашин хариуцагч, 2012 оны ЖАЙКА-ын бүсчилсэн сургалт ” хот суурин газар дах автомашинаас үүдэлтэй орчны бохирдолд авах арга хэмжээ” –ний сургалтанд оролцогч), Цэвэр агаарын сан, ШУТИС, (автомашинны техникийн засвар, үйлчилгээ болон агаарын бохирдолтой хамаарах талаар судалгаа хийж буй баг), ННТГ болон “Цахилгаан тээвэр” компани (утааны хий болон EURO стандартыг нэвтрүүлэх талаар ажиллаж буй мэргэжилтэн)-ий ажилтан зэрэг хүмүүс нь хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын талаар ерөнхий ойлголт авч, оролцогч талуудтай энэ талаар маргаан явуулсан. Иймэрхүү сургалтыг зохион байгуулсанаар холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцааг сайжруулах, НАЧА зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагын байр суурийг дээшлүүлэх талаар ажиллах нь зүйтэй юм.

Сургалтанд оролцогчид нь өөрсдийн хариуцсан ажил үүрэгт хэрэг болох эсэх талаар А үнэлгээг өгсөн хүн ихэнх нь байсан бөгөөд Microsoft Access-ыг ашигласан инвенторыг шинэчлэх ажлын хувьд хангалттай ойлгоогүй гэж хариулсан хүн цөөнгүй байсан. Иймээс ойлголтыг сайжруулахын тулд

Microsoft Access-ыг ашигласан инвенторын шинэчлэлийг тусгайлан авч үзсэн сургалтыг явуулсан бөгөөд энэ талаар ойлголт сайтай оролцогчид нь бусад нэгэндээ тайлбарлан тусалж байсан.

Хүснэгт 2.1-4 Сургалтын товч танилцуулга : Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор (3 дах жилийн)

Явагдсан огноо	2012/11/20 (Мягмар) 14:00~17:00
Газар	ЦУОШГ-ын сургалтын танхим
Цагийн хуваарь	14:00~ РРТ дээрх танилцуулга (асуулт хариулт) 16:00~Инвенторын тооцооллын дадлага ажил
Оролцогч	(НАЧА) АЛТАНГЭРЭЛ (ЦУОШГ) ЭНХМАА (УАЧМА) НЯМДАВАА, ӨНӨРБАТ (БОХТЛ) БАРХАСРАГЧАА (НАББҮХ) ЭНХЖАРГАЛ (ЦЭВЭР АГААР САН) БАЯРСАЙХАН (ШУТИС) БАТТОГТОХ (ЦАХИЛГААН ТЭЭВЭР КОМПАНИ) ЦЭЦЭГМАА (ННТГ) МЯГМАРСҮРЭН

Хүснэгт 2.1-5 Сургалтын товч танилцуулга : Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор (3 дах жилийн, нэмэлт дадлага)

Явагдсан огноо	2012/11/23(Баасан) 10:00~12:10
Газар	ЦУОШГ-ын сургалтын танхим
Цагийн хуваарь	10:00~Инвенторын тооцооллын дадлага ажил
Оролцогч	(НАЧА) АЛТАНГЭРЭЛ (УАЧМА) НЯМДАВАА, ӨНӨРБАТ, БАЯРМАГНАЙ (УЦУОШХ) ГАНСҮХ



Зураг 2.1-5 Сургалтын байдал

2.1.1.10 Бусад эх үүсвэрийн инвенторын сургалт (3 дах жилийн)

ДЦС II-ын үнсэн сангийн хэмжилтийн дүнгийн тэмдэглэл болон тооцооллын томъёог оруулсан EXCEL файлыг ашиглан хэмжилтийн дүнг оруулах, хэмжилтийн өгөгдлийг үнэлэх, хийсэлтийн хэмжээний тооцооллын дүнг магадлах ажлыг хийсэн. Хавсралт материал 2.1-11-т үзүүлэв.

Сургалтын товч агуулгыг Хүснэгт 2.1-6-д сургалт явагдаж буй байдлыг Зураг 2.1-6-т тус тус үзүүлэв.

Төсөлд хамтран ажиллагч талуудад тайлагнах, инвенторын шинэчлэлийг тогтмол хийж түүнийг үр дүнтэй ашиглах зорилгоор ДЦС-ын үнсэн сангийн инвентортой хамаарал бүхий оролцогч талаас гадна бусад холбогдох байгууллагын хүмүүсийг урьж оролцуулсан бөгөөд үүний үр дүнд БОХЗТЛ –ын мэргэжилтэн (зуны РМ-ын том ширхэглэлийн агууламж ихтэй байгаа талаар судалгааны зохиол хамтран бичсэн хүн), АББҮХ (ДЦС-ын хариуцан судалж буй мэргэжилтэн, сайжруулсан түлш хариуцагч мэргэжилтэн)-ны ажилтан үнсэн сангийн инвенторын ерөнхий байдлыг ойлгож мэдэн, оролцогч талын мэргэжилтэнтэй маргаан хийсэн. Иймэрхүү сургалтыг зохион байгуулсанаар холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа, харилцааг сайжруулах, НАЧА зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагын байр суурийг дээшлүүлэх талаар ажиллах нь зүйтэй юм.

Х/Т-ын байгууллагаас оролцогч нар сургалтын талаарх санал асуулгад ерөнхийдөө хангалттай ойлгосон гэж хариулж, өөрсдийн ажил үүрэгт хэрэг болно гэж дүгнэсэн.

Харин НАББҮХ-ноос оролцогчдын хувьд хангалттай ойлгож чадаагүй гэж хариулсан хэдий ч ажил үүрэгт хэрэг болно гэж хариулж, инвенторын ашиглалтын талаар мэдэж ойлгох боломжийг олгосон гэж үзсэн.

Хүснэгт 2.1-6 Сургалтын товч танилцуулга

Явагдсан огноо	2012/11/20 (Лхагва) 9:30~11:30
Газар	ЦУОШГ-ын сургалтын танхим
Цагийн хуваарь	9:30~ PPT дээрх танилцуулга тайлбар 10:30~ Асуулт хариулт 11:00~ Инвенторын тооцооллын дадлага ажил
Оролцогч	(НАЧА) САНЧИРБАЯР (ЦУОШГ) ЭНХМАА (УАЧМА) НЯМДАВАА, БАЯРМАГНАЙ (БОХТЛ) Бархасрагчаа (НАББУХ) ЭНХЖАРГАЛ, БАТТҮВШИН



Зураг 2.1-6 Сургалтын байдал

2.1.2 Эх үүсвэрийн инвенторын бүтэц

2.1.2.1 Эх үүсвэрийн инвенторын бүтэц, агуулга

Эх үүсвэрийн инвенторын бүтэц агуулгыг Хүснэгт 2.1-7-д үзүүлэв. УБ хотын агаарын бохирдлын байдлыг тодорхойлж мэдэхийн тулд эх үүсвэрийн инвенторын тооцооллыг хийсэн. Суурь он (2010 оны 3 сар ~ 2011 оны 2 сарыг хамруулсан)-д зуухны биечилсэн судалгаа, утааны хийн хэмжилт, хөдөлгөөний эрчим болон зорчих хурдны судалгаа гэсэн бүх холбогдох судалгааг явуулсан. Суурь оны эх үүсвэрийн инвентор, утааны хийн хэмжилтийн дүн, зуухны бүртгэлийн өгөгдөл, мэдээллийн дүнг тусгасан 2010 оны шинэчилсэн болон 2011 оны инвенторыг боловсруулж гаргасан.

Хүснэгт 2.1-7 Эх үүсвэрийн инвенторын бүтэц, агуулга

Үзүүлэлт	Агуулга
Хамруулсан хугацаа	Суурь он : 2010 оны 3сар~2011 оны 2 сар 2 дах удаагийн эх үүсвэрийн инвенторын шинэчлэл Шинэчлэл 1 (2010 оныг шинэчилсэн): Суурь онтой харьцуулан нүүрс зарцуулалтын хэмжээ болон ялгарлын коэффициент зэргийг дахин тооцооллосон. Шинэчлэл 2 (2011 он) : 2011 оны 3 сар~2012 оны 2 сар
Хамруулсан бодис	TSP, PM ₁₀ , SO _x (SO ₂), NO _x , CO
Хамруулсан эх үүсвэр	Суурин эх үүсвэр, хөдөлгөөнт эх үүсвэр, бусад эх үүсвэр
Хамруулсан бүс нутаг, масштабын нарийвчлал	УБ хотын төвийн 6 дүүргийг хамарсан нутаг дэвсгэр, 1000 м×1000 м
Үйл ажиллагааны эрчим	ДЦС-ын нүүрсний зарцуулалт, зуухны биечилсэн судалгаа, зуухны бүртгэлийн мэдээллийн сан, хөдөлгөөний эрчим болон зорчих хурдны судалгаа, үнсэн сангаас хийсэх үнсний судалгаа
Ялгарлын коэффициент	ДЦС болон УХЗ-ны утааны хийн хэмжилтийн судалгаа, өмнөх инвенторын дүн
Өмнөх судалгааны материал цуглуулах	Дэлхийн банкны зуухны зах зээлийн судалгаа, GIS газарзүйн зураг, ЖАЙКА-аас хэрэгжүүлсэн төрөл бүрийн мастер төлөвлөгөө, хороо тус бүрээрх хүн ам, бага оврын УХЗ-ны дүүрэгт тархсан байдал, гэрийн зуух болон ханын пийшингийн хороо тус бүрээр тархсан байдал

2.1.2.2 Эх үүсвэрийн инвенторын шинэчлэл**(1) Шинэчлэл 1**

2010 оны эх үүсвэрийн инвентор (мэргэжилтний дүгнэлт)—ийн хувьд Хүснэгт 2.1-8-т үзүүлсэнчлэн шинэчлэл засвар оруулж, 2010 оны инвенторыг боловсруулж гаргасан. Хүснэгтэнд оруулаагүй нүүрсний зарцуулалт, ялгарлын коэффициентийн хувьд 2.1.3-д үзүүлсэн байдлаар суурилуулалтыг ашигласан болно.

Хүснэгт 2.1-8 2010 оны инвенторын шинэчилсэн арга

Хамруулсан эх үүсвэр	Шинэчилсэн арга
ДЦС	Нүүрс зарцуулалтын хэмжээ : 75т/ц зуух болон 220 т/ц зуухны нүүрсний зарцуулалтыг хувиарлах аргыг дахин шалгаж өөрчилсөн. Я/К : 1 дэх жилийнхийг 2 дах жилийнхээр сольж шинэчилсэн.
УХЗ	Я/К : 1 дэх жилийнхийг 2 дах жилийнхээр сольж шинэчилсэн.
Бага оврын УХЗ	Талбайн хувиарлалтын аргыг хорооны талбайгаас хороо тус бүрээрх орон сууцны бус дүүргийн орон байрны эзлэх талбай болгож өөрчилсөн.
Гэрийн зуух	Талбайн хувиарлалтын аргыг хорооны талбайгаас хороо тус бүрээрх гэр хорооллын орон байрны эзлэх талбай болгож өөрчилсөн. Олон гэртэй айл өрхийн эзлэх хэмжээг 2% (Дэлхийн банкны өгөгдөл)-иас 20% (айл өрхийн тоо болон хэд хэдэн хороог сонгон аваад хиймэл дагуулын зурагт харагдаж буй гэрийн тоог тоолж гаргасан дүнгээс баримжаалан тооцооллох) болгож өөрчилсөн.
Автомашин хаягдал утаа	Я/К-ийн тооцоололд ашигласан автомашины мэдээллийн сангийн хувьд 2009 оны автомашины оношлогооны өгөгдлийг 2010 оны өгөгдөл болгож шинэчилсэн. Хотын хэмжээний хөдөлгөөний эрчмийн тооцоололд ашигласан түлшний зарцуулалтын өгөгдлийн хувьд 2009 оны УБ хотын Гаалийн газрын өгөгдлийг 2010 оны өгөгдөл болгож шинэчилсэн.
ДЦС-ын үнсэн сан	Үнсэнд агуулагдах РМ ₁₀ -ын хэмжээг скрубберийн амсарын утгаас үнсэн сангийн гадаргын үнсний РМ ₁₀ –ын хувь болгож өөрчилсөн.

(2) Шинэчлэл 2

2011 оны мэргэжилтний дүгнэлтийн инвенторыг Хүснэгт 2.1-9-т үзүүлсэн чиг баримтлалаар боловсруулсан. Хүснэгтэнд ороогүй нүүрсний зарцуулалт, Я/К-ийн хувьд 2010 оны инвенторын суурилуулалтыг ашигласан болно.

Хүснэгт 2.1-9 2011 оны инвенторыг боловсруулсан арга

Хамруулсан эх үүсвэр	Боловсруулсан арга
ДЦС	Нүүрс зарцуулалт : 2011оны 3 сар~2012 оны 2 сард шинэчилсэн.
УХЗ	Зуухны бүртгэлийн тогтолцооны хүрээнд бүртгэгдсэн УХЗ-ыг ашигласан.
Бага оврын УХЗ	Зуухны зарцуулалтыг 2010 он ~ 2011оны хүн амын өсөлтийн хэмжээгээг нэмэгдүүлсэн.
Гэрийн зуух	2010 оны айл өрхийн тоо, ханын пийшин хэрэглэж буй айл өрхийн тоог 2010 он~2011 оны хүн амын өсөлтийн хэмжээгээгээр нэмэгдүүлсэн.
Автомашин хаягдал утаа	Я/К-ийн тооцоололд ашигласан автомашины мэдээллийн сангийн 2010 оны оношлогооны өгөгдлийг 2011 оны оношлогооны өгөгдлөөр шинэчилсэн. Хөдөлгөөний эрчим нь 2010 оны хөдөлгөөний эрчмийн судалгааны хөдөлгөөний эрчмийг VDS камерийн хөдөлгөөний эрчмийн утгаар тооцоолсон 2010 онд 2011 оны хөдөлгөөний эрчмийн харьцаанд үржүүлсэнийг 2011 оны хөдөлгөөний эрчим гэж авч үзсэн. Хотын нийт нутаг дэвсгэрийн хөдөлгөөний эрчмийн тооцоололд ашигласан түлшний зарцуулалтын өгөгдлийг 2011 оны УБ хотын Гаалийн газрын өгөгдлөөр шинэчилсэн.
ДЦС-ын үнсэн сан	Үнсний хийсэлтийн хэмжээний өгөгдлийг 2012/3/21 ~ 5/22 хоорондох өгөгдлөөр шинэчилсэн. Хөрсөөр хучигдсан байдал зэрэг мэдээллийг 2011 оны байдлаар шинэчилсэн.

2.1.3 Эх үүсвэрийн төрөл тус бүрийн үйл ажиллагааны эрчим болон Я/К-ийн суурилуулалт

2010 он болон 2011 оны эх үүсвэрийн инвенторыг УБ хотын агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг хамгийн бага, хамгийн их, мэргэжилтний дүгнэлт гэсэн 3 төрөлд хувааж тооцоолсон. Суурин эх үүсвэр болон бусад эх үүсвэрийн хувьд хамгийн бага, хамгийн их, мэргэжилтний дүгнэлтийн утгын суурилуулалт болон өгөгдлийн итгэлцлүүрийн түвшинг Хүснэгт 2.1-10-т үзүүлэв. Хамгийн бага хувилбар нь Я/К болон үйл ажиллагааны эрчим (нүүрсний зарцуулалтын хэмжээ зэрэг)-г хамгийн бага байхаар дүгнэж суурилуулсан бол хамгийн их хувилбар нь Я/Кболон үйл ажиллагааны эрчмийг хамгийн их гэж үзэж суурилуулсан утга болно.

Мэргэжилтний дүгнэлтийн хувилбарын тухайд Я/К болон үйл ажиллагааны эрчмийн хамгийн багаас хамгийн их утгын хамрах хүрээнд УБ хотын өнөөгийн нөхцөл байдалд хамгийн таарсан гэж үзэж мэргэжилтний дүгнэж гаргасан утгын суурилуулалт юм. Өгөгдлийн итгэлцүүрийн түвшин нь хамруулсан эх үүсвэрээс шалтгаалж нэлээд зөрүүтэй байна. Жишээлбэл: ДЦС-ын нүүрсний зарцуулалтын хэмжээ, Я/К-ийн тухайд бодит хэмжилтийн өгөгдлүүд байдаг бөгөөд эдгээр нь нарийвчлал өндөртэй хийгдсэн байдаг. Түүнтэй харьцуулахад PM10 хөрснөөс хийсэх тоос шорооны хийсэлтийн хэмжээний хувьд тооцооллох үндэслэл нь болох Я/К нь замын тоос (silt) –ны агууламжаас ихээхэн шалтгаалдаг. Энэ тоос (silt)-ны эзлэх хувь засмал замд 0.03~400-н хооронд байдаг. Тиймээс Я/К нь итгэлцлүүрийн түвшин багатайн дээр оруулах утгын зөрүүнээс болоод хийсэлтийн хэмжээнд их зөрүү үүсээд байна.

Цаашид ялгарлын хэмжээний дүн шинжилгээ болон тархалтын загварчлалд үндсэндээ мэргэжилтний дүгнэлтийн хувилбарыг ашиглан үнэлгээг хийсэн болно.

Хүснэгт 2.1-10 Эх үүсвэрийн төрөл тус бүрийн үйл ажиллагааны эрчим болон Я/К

Эх үүсвэр	Зүйл	Хамгийн бага	Хамгийн их	Мэргэжилтний дүгнэлт
ДЦС	Нүүрсний зарцуулалт	ДЦС-ын тайлангийн дүн		
	Я/К	ДЦС бүрт хийгдсэн утааны хийн хэмжилтийн дүнгээс нүүрсний зарцуулалтын жигнэсэн дундаж утга	ДЦС бүрт хийгдсэн хэмжилтийн дүнгийн хамгийн их утга	
	Өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин	Нүүрсний зарцуулалтыг ДЦС-ын тайланд тулгуурлан утгыг суурилуулсан тул өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин нэлээд өндөртэй гэж үзэх Я/К-ийг утааны хийн хэмжилтийн дүнд тулгуурлан утгыг суурилуулсан тул өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин нэлээд өндөртэй гэж үзэх		
УХЗ	Нүүрсний зарцуулалт	Зуухны газар дээр биечлэн хийсэн судалгааны дүнгийн өгөгдөл		
	Я/К (Ижил төрлийн УХЗ-нд хэмжилт хийгдээгүй)	Хэмжилт хийсэн УХЗ-ны төрөл тус бүрээр хамгийн бага жигнэсэн дундаж утга	Хэмжилт хийсэн УХЗ-ны төрөл тус бүрээр хамгийн их жигнэсэн дундаж утга	Хэмжилт хийсэн УХЗ-ны төрөл тус бүрийн жигнэсэн дундаж утга
	Өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин	Нүүрсний зарцуулалтыг зуухны байгууламжид биечлэн хийсэн судалгаанд тулгуурлан утгыг суурилуулсан тул итгэлцлүүрийн түвшин харьцангуй өндөр байгаа. Хэмжилтэнд хамруулсан УХЗ-ны Я/К-ийг утааны хийн хэмжилтийн судалгааны дүнд тулгуурласан байгаа тул найдвартай итгэлцлүүрийн түвшин өндөртэй гэж үзэх. Гэхдээ ижил төрлийн УХЗ-нд хийгдсэн хэмжилтийн хувьд утааны хийн хэмжилтийн дүнгээр тооцоолж байгаа тул итгэлцлүүрийн түвшин дунд зэрэг байна.		
Бага оврын УХЗ	Нүүрсний зарцуулалт	Дэлхийн банкны НОВ Market Study (2009)-ны зуухны судалгааны өгөгдлөөс суулгасан.		
	Я/К	Нарийвчилсан төлөвлөгөөний судалгаа болон төслийн эхний жилийн утааны хийн хэмжилтийн дүнгээс гаргасан утга		
	Өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин	Нүүрсний зарцуулалтыг Дэлхийн банкны судалгаанд тулгуурласан тул итгэлцлүүрийн түвшин дунд зэрэг гэж үзэх. Я/К-ийг утааны хийн хэмжилтийн дүнд тулгуурласан бөгөөд хэмжилт хийгдсэн тоо цөөхөн болохоор итгэлцлүүрийн түвшин дунд зэрэг гэж үзэх.		
Гэрийн зуух (Ханийн пийшинг хамруулсан)	Нүүрсний зарцуулалт	○Нүүрс : 3т/машин/ж (гэр), 4т/машин/ж (хана) ○Түлээ : 3.27т/машин/ж (гэр), 2.99т/машин/ж (хана)	○Нүүрс : 3.49т/машин/ж (гэр), 4.49т/машин/ж (хана) ○Түлээ : 3.27т/машин/ж (гэр), 2.99т/машин/ж (хана)	

		2 зуухтай өрх айлыг 2.1% гэж үзэх ¹	2 зуухтай өрх айлыг 25% гэж үзэх ²	2 зуухтай өрх айлыг 2.1% гэж үзэх ³
Я/К	<ul style="list-style-type: none"> ○ Нүүрсийг нарийвчилсан судалгааны Я/К-ийг үндэс болгон ашиглаж зөвхөн СО-г төслийн УХЗ-ны дундаж Я/К-ийг ашиглах ○Түлээг GAP Forum Manual-ын утгыг ашиглан (PM₁₀ : Нүүрс (гэр) 3.3, Нүүрс (хана) 2.1, Түлээ (гэр, хана) 3.82) 	<p>Дэлхийн банкны агаарын мониторинг, агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаарх суурь судалгаа буюу AMНВ, 2009 оны утгад өөрчлөлт, PM₁₀(гэр-хана) : Нүүрс 16.0, Түлээ 18.5), СО (нүүрс)-ийн Я/К-ийг УХЗ-ны төрөл тус бүрийн Я/К-ийн дотроос хамгийн их утга (389.71)-ыг ашиглах</p>	СО –оос бусад нь хамгийн бага хувилбартай адилхан. СО (нүүрс)-ын Я/К нь УХЗ-ны зуух тус бүрийн Я/К-ийн эхний байрын 5 зуухны дундаж утга (173.34)-ыг ашиглах	
Өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин	<p>Нүүрсний зарцуулалтыг Дэлхийн банкны судалгаанаас авч ашигласан бөгөөд энэ судалгаа нь бодит хэмжилтэнд тулгуурласан судалгаа биш учраас итгэлцлүүрийн түвшин багатай гэж үзэх.</p> <p>Я/К-ийн хувьд хэмжилт хийсэн тоо цөөхөн учраас итгэлцлүүрийн түвшин дунд зэрэг гэж үзэх.</p>			
Авто машины хаягдал утаа	Үйл ажиллагааны эрчим	<p>Гол автозамын үйл ажиллагааны эрчимд тус төслийн хүрээнд хийгдсэн хөдөлгөөний эрчмийн судалгааны өгөгдлийг ашигласан.</p> <p>Бусад автозамын хувьд бусад замын түлшний зарцуулалтаас баримжаалан тооцоолсон бөгөөд түлшний зарцуулалтын хэмжээ нь бензин болон дизель түлшний нийт импортын хэмжээний дотроос УБ хотын Гаалийн газрын мэдээлэлд бүртгэгдсэн хэмжээнээс гол автозамын үйл ажиллагааны эрчмийн өгөгдлөөс тооцоолж гаргасан гол замын түлшний зарцуулалтын хэмжээг хасаж тооцоолсон.</p>		
Я/К		<p>Японы Я/К-д УБ хотын автомашины оношлогооны газрын 2009 онд хийгдсэн автомашины оношлогооны өгөгдлөөс тооцоолж гаргасан автомашины төрөл тус бүрийн хаягдал утааны хийн ялгарлын хэм хэмжээ бүрийн туулсан зайн харьцаагаар жигнэсэн дундаж болгож тооцоолсон.</p>		
		Түлшнээс үүдэлтэй хордуулалт болон оношлогоонд тэнцээгүй автомашиныг хасч, элэгдэж муудаагүй гэж үзээд тооцоолсон.	Импортоор орж ирээд 2-оос дээш жил өнгөрсөн автомашиныг бүхэлд нь элэгдэж муудсан гэж авч үзсэн.	Импортоор орж ирээд 1-ээс дээш жил болсон автомашиныг бүхэлд нь элэгдэж муудсан гэж авч үзсэн.
Өгөгдлийн итгэлцлүүрийн түвшин	<p>Хөдөлгөөний эрчим, японы Я/К-ийн хувьд В түлшний химийн найрлагын мэдээлэл, итгэлцлүүрийн түвшин өндөртэй байгаа. Мөн түлш зарцуулалтын хувьд УБ хотын Гаалийн газрын өгөгдөлтэй харьцуулсан</p>			

¹Эх сурвалж: Heating in Poor, Peri-Urban Ger Areas of Ulaanbaatar, World bank, 2009

²Эх сурвалж: Тус төслийн судалгааны утга (Дүүрэг тус бүрээс дурын хороог сонгож, сансарын зургаас тоолсон гэрийн тоог хүн амын статистикийн хороонд хуваасан дундаж утга)

³Эх сурвалж: хамгийн их хувилбартай адилхан.

Бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ = үйл ажиллагааны эрчим × Я/К гэсэн томъёогоор тооцоолсон. Үйл ажиллагааны эрчмийг ДЦС тус бүрээс авсан асуулга ярилцлага, үнсэн дээр хийгдсэн бодит судалгаа зэрэгт үндэслэн хийсэх магадлалтай талбай хэмжсэн. Я/К-ийг тус төслийн хүрээнд хийгдсэн үнсний хийсэлтийн хэмжээний судалгааны өгөгдлийг ашиглан тооцоолсон болно.

Эх үүсвэрийн төрлийн хувьд талбайн эх үүсвэр гэж үзээд эх үүсвэрийн инвенторыг боловсруулсан.

Хүснэгт 2.1-24 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээний тооцооллын арга, үйл ажиллагааны эрчим, Я/К болон эх үүсвэрийн төрөл, хувиарлалт

	Ялгарлын хэмжээг тооцооллох арга	Үйл ажиллагааны эрчим	Я/К	Эх үүсвэрийн төрөл, хувиарлалт
ДЦС-ын үнсэн сан	Ялгарлын хэмжээ = Хийсэх магадлалтай талбай × Агаар бохирдуулах бодис тус бүрийн Я/К	ДЦС –ээс авсан ярилцлага, асуулга, бодит судалгааны дүн зэргээс тодорхой болсон үнс хийсэх магадлалтай талбай	Тус төслийн хүрээнд хийгдсэн үнс хийсэх хэмжээний судалгааны өгөгдлөөс тооцоолж гаргасан. TSP-ээс PM ₁₀ -ын шилжүүлэхдээ зуухнаас гарах үнсний ширхэглэлийн тархалт болон үнсэн санг хучсан гадаргын үнсний ширхэглэлийн хэмжээний тархалтаас тооцоолсон PM ₁₀ -ын хувийг үржүүлэн бодож гаргасан.	Эх үүсвэрийн төрөл: талбайн эх үүсвэр

(2) Инвенторын өгөгдлийг шинэчлэх арга

1) ДЦС-ын үнсэн сан

Үнсэн сан тус бүрээр ялгарлын хэмжээг тооцоолсон.

ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнсний инвенторын тооцоололд шаардлагатай өгөгдөл, үзүүлэлт болон ялгарлын хэмжээг тооцооллох процессыг Хүснэгт 2.1-25-д үзүүлэв.

PM₁₀ Ratio sheet-д үнсэнд агуулагдах 10 микрон хүрэхгүй диаметртэй тоосонцорын хэмжээг оруулан тооцоолсон байгаа. Шаталтын арга зэргийг өөрчилсөн тохиолдолд зөвхөн үнсэнд агуулагдах 10 микроноос дооших диаметртэй тоосонцорын хувийг хэмжиж шинэчилсэн.

Emission sheet-д үнсэн сангийн талбай, хийсэх магадлалтай гадаргуун талбайн хэмжээ, элэгдлийн гүн, хуурайшилтын нягтшлийн өгөгдлийг оруулж, хэмжилт хийгдсэн хугацаан дах хийсэлтийн хэмжээг

тооцоолсон. Мөн дараагийн Pattern sheet-д тооцоолсон сар бүрийн хийсэлтийн хэмжээнээс жилийн хийсэлтийн хэмжээг тооцоолж гаргасан. Хийсэх магадлалтай гадаргын талбайн хэмжээ нь үнсэн сангийн хяналт (хөрсөөр хучих, усаар дүүргэж зэрэг) –ын байдлаас хамааран өөрчлөгдөж байдаг тул жил бүр өгөгдлийг шинэчлэх шаардлагатай юм. Элэгдлийн гүн болон хуурайшилтын нягтшлийг шинээр хэмжсэн тохиолдолд эдгээр утгыг бас шинэчлэх юм.

Pattern sheet-д сар тус бүрийн хийсэлтийн хувийг суурилуулж өгч, сар тутмын TSP-ын хийсэлтийн хэмжээ болон PM-10-ын хийсэлтийн хэмжээг тооцоолсон . Бүтэн жилийн туршид хөрсний элэгдлийн зузааныг хэмжих ажил амжилттай хийгдсэн зэрэг сар тутмын хийсэлтийн хувь хэмжээний талаар шинэ мэдээлэл олж авсан тохиолдолд тохирох утгыг шинэчлэх ёстой юм.

Дээрх өгөгдлөөс Pattern sheet-д сар тутмын ялгарлын хэмжээг, Emission sheet-д жилийн нийт ялгарлын хэмжээг тус тус тооцоолсон .

Хүснэгт 2.1-25 ДЦС-ын үнсэн сангийн хийсэлтийн инвенторт шаардлагатай үзүүлэлт болон тооцооллын жишээ

Sample Name	PM10 Ratio
PP2, No.3 Boiler (35ton/h), Scrubber Entrance	7.06%
PP2, No.5 Boiler (70ton/h), Scrubber Entrance	23.53%
PP3, No.4 Boiler, Entrance	7.83%
PP3, No.6 Boiler, Entrance	17.99%
PP3, No.7 Boiler, Entrance	33.39%
PP3, No.10 Boiler, Entrance	29.76%
PP3, No.4 Boiler, Scrubber Entrance	5.97%
PP3, No.6 Boiler, Scrubber Entrance	22.24%
PP3, No.7 Boiler, Scrubber Entrance, Left	30.82%
PP3, No.10 Boiler, Scrubber Entrance, Left	25.01%
average	20.4%

PP	Area Name	Square (m ²)	fugitive area (%)	Average erosion depth (cm)	TSP emission (ton)	TSP_TPY	PM10_TPY
PP2	West	50,882	100%	0.576	1.29	378	986.77
	East	55,968	0%	0.576	1.29	0	0.00
	Subtotal					378	986.77
PP3	1	123,000	0%	0.576	1.29	0	0.00
	2	141,000	0%	0.576	1.29	0	0.00
	3	119,000	0%	0.576	1.29	0	0.00
	4	102,600	100%	0.576	1.29	762	1,989.76
	5	60,000	0%	0.576	1.29	0	0.00
	Subtotal					762	1,989.76
PP4	3	250,000	40%	0.576	1.29	743	1,939.33
	4	160,000	25%	0.576	1.29	297	775.73
	5	180,000	70%	0.576	1.29	936	2,443.56
	Subtotal					1,976	5,158.63
Total						3,117	8,135.16

Month	Average wind	Inverse of wind	Pattern	Pattern for simulation	Maximum temperature	Minimum temperature	West	East	Subtotal	PP2	PP3	PP4	Total
1	1.3	0.769	1	0.046	-7.3	-32.2	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
2	1.9	0.526	1	0.046	-1	-30.1	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
3	2.8	0.357	10	0.460	9.9	-23.7	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
4	3	0.333	50	2.298	20.1	-14.3	189,098	0	189,098	0	0	0	189,098
5	3.7	0.270	100	4.598	27.9	-8.3	378,073	0	378,073	0	0	0	378,073
6	3.3	0.303	50	2.298	30.4	1.3	189,098	0	189,098	0	0	0	189,098
7	3.1	0.323	30	1.378	30.9	5.3	113,424	0	113,424	0	0	0	113,424
8	2.8	0.357	10	0.460	29.3	3.2	37,807	0	37,807	0	0	0	37,807
9	2.4	0.417	5	0.230	25	-5.1	18,903	0	18,903	0	0	0	18,903
10	2	0.500	2	0.092	19.4	-14.9	7,561	0	7,561	0	0	0	7,561
11	1.9	0.526	1	0.046	5.9	-25.1	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
12	1.9	0.526	1	0.046	-4.9	-31.5	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
Subtotal			261				986,772	0	986,772	0	0	0	986,772

2.1.5 Эх үүсвэрийн инвентор боловсруулалтын дүн

2010 он болон 2011 оны мэргэжилтний дүгнэлтийн эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээг Хүснэгт 2.1-26-д үзүүлэв. Мөн 2010 оны бүх эх үүсвэрээс ялгарах PM10-ын ялгарлын хэмжээний тархалтыг Зураг 2.1-14-д үзүүлэв. TSP-ын ялгарлын хэмжээний хувьд ДЦС хамгийн их, дараа нь гэрийн зуух, замын тоос шороо гэсэн дараалалтай байна. PM10-ын ялгарлын хэмжээгээр ДЦС хамгийн их, дараа нь замын тоос шороо, гэрийн зуух гэсэн байдалтай байна. SOx болон NOx-ын ялгарлын хэмжээгээр ДЦС, гэрийн зуух гэж дараалж байгаа бөгөөд ДЦС болон гэрийн зуухны ялгарлын хэмжээ нь нийт ялгарлын хэмжээний 90% орчмыг эзэлж байна. CO ялгарлын хэмжээний хувьд гэрийн зуух нь нийт ялгарлын хэмжээний 60% орчмыг эзэлж байгаа нь автозамаас үүдэлтэй ялгарлын хэмжээнээс бараг 2.5 дахин их гарч байгааг тогтоосон. Үйл ажиллагааны эрчим, ялгарлын коэффициентийн суурилуулалт, 2010 оноос бусад үеийн ялгарлын хэмжээний дэлгэрэнгүй Хавсралт материал 2.1-13-д үзүүлэв.

2010 он болон 2011 оны ялгарлын хэмжээний харьцуулсан дүнг Зураг 2.1-13-т үзүүлэв. TSP-ын ялгарлын хэмжээний хувьд ДЦС-ын PM_{10} -ын ялгарлын хэмжээ нь 2010 оноос 2011 он хүртэл өөрчлөгдөөгүй байгаа хэдий ч гэрийн зуухны ялгарлын хэмжээ нь бараг 600 тонн/жил-ээр багассан байна. УХЗ-ны хувьд 2011 он гэхэд бараг 260 тонн/жил-ээр багассан байна.

SOx болон NOx-ын ялгарлын хэмжээний хувьд 2010 оноос 2011 он хүртэл бүх эх үүсвэрийн хэмжээнд томоохон өөрчлөлт гараагүй.


CO-ын ялгарлын хэмжээгээр хэсэгчилсэн эх үүсвэрт жил бүрийн хувьд их өөрчлөлт гараагүй ч гэрийн зуухны хувьд 62,078 тонн/жил-ээс 59,070 тонн/жил болж багассан байна.

Мөн 2011 онд төрөөс татаас мөнгө олгосны дагуу 63,224 ширхэг борлуулагдсан бүтээмж сайтай сайжруулсан зуухны хувьд утааны хийн урсгал хурд багатай, агууламжийн өөрчлөлт ихтэй байгаа тул хэмжилт хийхэд бэрхшээлтэй, хэмжилтийн дээжийн тоо цөөн, утгын хэлбэлзэл ихтэй байгаа юм. Утааны хийн агаар бохирдуулах бодисын агууламжийн өгөгдлийг ашиглан ялгарлын хэмжээг тооцоолж байгаа бөгөөд оршин суугчдаас галлагааны аргачлалын талаар санал асуулга авах мөн тус аргачлалд тулгуурласан утааны хийн хэмжилт хийснээр хэмжилтийн дүнгийн нарийвчлалыг сайжруулах шаардлагатай юм.


Хүснэгт 2.1-26 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээ (мэргэжилтний дүгнэлтийн хувилбар)

Нэгж : тонн/жил

	TSP		PM10		SOx		NOx		CO	
	2010 он	2011 он	2010 он	2011 он	2010 он	2011 он	2010 он	2011 он	2010 он	2011 он
ДЦС	19,826	20,108	12,887	13,070	10,545	10,667	14,251	14,275	8,481	8,484
УХЗ	2,011	1,607	1,307	1,044	764	830	126	146	4,970	5,944
Бага оврын УХЗ	218	246	131	148	313	354	103	116	463	524
Гэрийн зуух	7,720	7,466	5,018	4,853	4,258	4,627	592	657	62,078	59,070
Автозам	195	212	195	212	204	257	4,186	3,303	24,293	16,462
Нарийн зам	31	33	31	33	32	40	654	516	3,795	2,572
Тоос шороо	6,812	6,644	6,812	6,644	-	-	-	-	-	-
Үнс хийсэлт	8,135	3,105	1,950	956	-	-	-	-	-	-
Нийт	44,948	39,420	28,331	26,959	16,116	16,775	19,912	19,013	104,080	93,056



Зураг 2.1-13 2010 он болон 2011 оны ялгарлын хэмжээний харьцуулалт



Зураг 2.1-14 PM₁₀ –ын ялгарлын хэмжээний тархалт (2010 он)


2.1.6 Тархалтын загварчлалын модель боловсруулах арга**2.1.6.1 Тархалтын загварчлалыг тооцооллох нөхцөл, үндсэн бүтэц****(1) Тархалтын загварчлалыг тооцооллох нөхцөл**

Энэ удаа тооцоолж гаргасан тархалтын загварчлалын моделийг тооцооллын нөхцөлийг Хүснэгт 2.1-27, тархалтын загварчлалын үндсэн бүтцийг Зураг 2.1-15-д тус тус үзүүлэв. Тархалтын загварчлалын модельд оруулах өгөгдөл нь агаар орчны өгөгдөл, цаг уурын өгөгдөл, эх үүсвэрийн өгөгдөл юм. УБ хотын суурин харуулд мониторинг хийж байгаа PM_{10} , SO_x , NO_x , CO , WD (салхины чиг), WS (салхины хурд)-ийг модельд оруулан боловсруулалт хийсэн. Мөн адил эх үүсвэрийн инвенторыг модельд оруулан боловсруулсан. Эдгээр ажиллагааг цаг уурын өгөгдлийн хувиргалт болон эх үүсвэрийн хувиргалтаар гүйцэтгэсэн.

Хүснэгт 2.1-27 Тархалтын загварчлалын үндсэн нөхцөл

Үзүүлэлт	Агуулга	
Ашиглах загвар ISC-ST3 (US-EPA)+Puff Model	Хамрагдах бүс нутаг	Хотын захын, хотын төв нийслэл, үйлдвэрийн бүс нутаг
	Газрын хэлбэр	Тооцооллын грид тус бүрийн далайн дундаж түвшингөөс өндөр газрын хэлбэрийг харгалзан үзэх
	Хамруулах утааны эх үүсвэр	Өндөр утааны эх үүсвэр, гадаргын утааны эх үүсвэр
Хамруулах бодис	PM_{10} , SO_x (SO_2), CO , NO_x (NO , NO_2)	
Эх үүсвэр	Суурин эх үүсвэр, Хөдөлгөөнт эх үүсвэр, Бусад эх үүсвэр	
Хамруулсан хугацаа	2010 оны 11 сар~2011 оны 2 сар	
Цаг уурын өгөгдлийн дүн шинжилгээ	Цаг уурын өгөгдлийг дүн шинжилгээ хийж, модельд оруулах өгөгдөл болгон өөрчлөх.	
Агаарын орчны өгөгдлийн дүн шинжилгээ	Сар, жилийн дундаж тоон утга, цаг тутмын өөрчлөлт зэрэг үндсэн анализ, дүн шинжилгээг хийснээр УБ хотын АБ-ын нөхцөл байдлыг шинжлэх.	
Хамрагдах бүс нутаг, нарийвчлалын хэмжээ	өв хэсгийг хамруулсан 34км×28км, нарийвчлалын хэмжээ 1км×1км	

Өгөгдөл боловсруулалт



Зураг 2.1-15 Тархалтын загварчлалын моделийн үндсэн бүтэц

(2) **Моделийн үндсэн бүтэц**

Тархалтын загварчлалын модельд USEPA-аас гаргасан ISCST3 моделийг ашигласан. Гэвч ISCST3 модельд салхины хурд 1 м/с-ээс доош байгаа цаг уурын нөхцөлд агууламжийг тооцоолдоггүй тул тийм тохиолдолд Puff моделийг ашигласан.

ISCST3-д ашиглаж буй Plume томъёог үзүүлбэл,

$$\chi = \frac{QKVD}{2\pi u_s \sigma_y \sigma_z} \exp \left[-0.5 \left(\frac{y}{\sigma_y} \right)^2 \right]$$

χ : Concentration ($\mu\text{g}/\text{m}^3$)

Q : Pollution emission rate (mass per unit time)

K : Scaling coefficient to convert calculated concentration to desired units
(default value of 1×10^6 for Q in g/s and concentration in $\mu\text{g}/\text{m}^3$)

V : Vertical term

D : Decay term

σ_x, σ_y : Standard deviation of lateral and vertical concentration distribution (m)

u_s : Mean wind speed (m/s) at release height

Puff моделийн томъёо нь дараах болно.

$$C(R, z) = \frac{1}{\sqrt{2\pi}} \cdot \frac{Q_p}{\frac{\pi}{8} \gamma} \cdot \left\{ \frac{1}{\eta_-^2} \cdot \exp\left(-\frac{u^2(z - He)^2}{2\gamma^2 \eta_-^2}\right) + \frac{1}{\eta_+^2} \cdot \exp\left(-\frac{u^2(z + He)^2}{2\gamma^2 \eta_+^2}\right) \right\}$$

$$\eta_-^2 = R^2 + \frac{\alpha^2}{\gamma^2} (z - He)^2$$

$$\eta_+^2 = R^2 + \frac{\alpha^2}{\gamma^2} (z + He)^2$$

$$R^2 = x^2 + y^2$$

- R : Horizontal distance from point source to calculation point
 Q_p : Emission (m³N/s)
 U : Wind speed (m/s)
 He : Effective plume height (m)

(3) Яндангийн ашиглалтын өндөр (effective height)-ийн тооцоолол

Яндангийн ашиглалтын өндөр буюу effective height (he) гэдэг нь яндангаас ялгарах хий нь өөрт хадгалагдах дулаан болон яндангаас баагиж гарах хурднаас хамаарах хөдөлгөөний эрчмээр тодорхой өндөрт хүрч дээшилсэн тухайн өндрийг хэлдэг. Энэ өндөрт хүрсэний дараа салхиар агаарт тархаж эхэлдэг бөгөөд өөрөөр хэлбэл, хэвтээ чиглэлийн салхи нь ижил эрчтэй байх үед яндангийн ашиглалтын өндөр нь өндөр байх тусам тархалт өргөн хүрээнд явагдсанаар бохирдуулах бодис нь тэр хэмжээгээр жигд тархаж нимгэрдэг байна. Ингэснээр орчны агууламжийг багасгаж чаддаг. Хэвтээ чиглэлийн салхи жигд байгаа үед яндангийн ашиглалтын өндрийг өндөрсгөхийн тулд утааны хийн температур, хурд болон яндангийн өндрийг аль болох өндөр их, яндангийн диаметр нь бага байх шаардлагатай юм.

Агаарын тогтвортой байдал нь тогтворгүй эсвэл дундаж саармаг нөхцөл байдалтай байхад ISC-ST3 моделийн яндангийн ашиглалтын өндрийг дараах томъёогоор бодож олно.

$$h_e = h_s' + 21.425 \frac{F_b^{3/4}}{u_s} \quad F_b < 55$$

$$h_e = h_s' + 38.71 \frac{F_b^{3/5}}{u_s} \quad F_b \geq 55$$

Chip stack downwash буюу яндангаас гарах утааны хийн яндангийн нөлөөллөөр яндан орчмын салхины эргүүлэгт орж доошлох байдлыг бодолцож үзсэний үндсэн дээр яндангаас гарах өндөр (h_s') болон Buoyancy flux parameter (дээшилж хөөрөх урсгалын параметр) (F_b)-ийг дараах томъёогоор бодож гаргасан.

$$F_b = g v_s d_s^2 \left(\frac{\Delta T}{4T_s} \right)$$

$$h_s' = h_s + 2d_s \left(\frac{v_s}{u_s} - 1.5 \right) \quad v_s < 1.5$$

$$h_s' = h_s \quad v_s \geq 1.5$$

- u_s : яндангаас гарах өндрийг засварласан хэвтээ чиглэлийн салхины хурд (м/с)
 g : таталцлын хүчний хурд (Gravity force) (м/с²)


vs	: утааны хийн хурд (м/с)
ds	: яндангийн диаметр (м)
ΔT	: утааны хийн температур (T_s) болон агаарын температур (T_a)-ын зөрүү (К)
hs	: яндангийн бодит өндөр (м)

2.1.6.2 Цаг уурын өгөгдөл болон агаар орчны өгөгдлийн дүн шинжилгээ

(1) Цаг уурын өгөгдөл

ЦУОШГ-аас авсан цаг уурын өгөгдлийг ашигласан. Салхины тархалтыг Шулуун зураас: Салхины чиглэл бүрийн давтамж, Тасархай зураас: Салхины чиглэл бүрийн дундаж хурд

Зураг 2.1-16-т үзүүлсэн бөгөөд салхины тархалт нь зүүнээс баруун зүгийн салхины давтамж өндөртэй байгаа нь УБ хотын газарзүйн онцлогийг харуулсан байна. Гэвч бүтэн жилийн цаг уурын өгөгдлийн хэмжигдсэн хугацаа нь 6000 цагаас илүү байгаа нь тархалтын загварчлалын моделийн нарийвчлалд багагүй нөлөө үзүүлж байна.




Шулуун зураас: Салхины чиглэл бүрийн давтамж, Тасархай зураас: Салхины чиглэл бүрийн дундаж хурд

Зураг 2.1-16 Салхины тархалт (2010 он 3 сар ~2011 он 2 сар)

(2) Агаар орчны өгөгдөл


Тархалтын загварчлалын нарийвчлалын хувьд агаар орчны агууламжийн хэмжилтийн утгатай тархалтын загварчлалаар тооцоолж гаргасан тооцооллын утгыг харьцуулан үнэлэх нь зүйтэй юм. Иймд агаар орчны агууламжийн хэмжилтийн утгыг цуглуулж, агаарын бохирдлын ерөнхий байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

Агаарын бохирдлыг тасралтгүй хэмжигч хэмжилтийн багаж төхөөрөмж суурилуусан газрыг Зураг 2.1-17-д үзүүлэв.




Зураг 2.1-17 АБ-ын хэмжилтийн цэгүүд (зөвхөн тасралтгүй хэмжигч төхөөрөмж суурилуулсан цэгүүд)


Сар тус бүрийн агууламжийн өөрчлөлтийг Зураг 2.1-18~Зураг 2.1-22-д тус тус үзүүлэв. Зурагт улаан болон шаргал өнгөөр тэмдэглэсэн шулуун шугамаар тус бүрийн БО-ны стандартын утгыг харуулсан болно. Зургаас харахад PM_{10} болон SO_2 -ын хувьд 12 сар~1 сарын хооронд агууламж өндөртэй, NO , NO_2 болон CO нь 9 сар~4 сарын хоорондох халаалтын улиралд агууламж өндөртэй байна. БОХЗГЛ-ын хэмжилтийн утгад үндэслэсэн дүн шинжилгээ (Хавсралт материал 2.1-5)-нд PM_{10} , SO_2 , NO_2 -ын үзүүлэлт нь бүх хэмжилтийн цэгт жилийн дундаж стандартын утгаас давсан байгаа юм. Харин CO -ын хувьд ихэвчлэн стандартаас хэтрээгүй байна.




Зураг 2.1-18 Сур тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (PM₁₀)




Зураг 2.1-19 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (SO₂)



Зураг 2.1-20 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (NO)



Зураг 2.1-21 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (NO₂)



Зураг 2.1-22 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (CO)

2.1.6.3 Тархалтын загварчлалын модель гаргалт

(1) Эх үүсвэрийн ялгарлын өндөр (нийтлэг)

Эх үүсвэр тус бүрийн ялгарлын өндрийг Хүснэгт 2.1-28-д үзүүлэв. Утааны хийн агаарт тархах өндрийг яндангийн effective height -ийн баримжаалсан тооцооллын аргыг ашиглан тооцоолсон.

Хүснэгт 2.1-28 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын өндөр

Эх үүсвэр	Ялгарлын өндөр
ДЦС, УХЗ, үйлдвэр	Яндангийн өндөр + Утааны хийн агаарт тархах өндөр
Бага оврын УХЗ	5 м
Гэрийн зуух (ханан пийшин)	3 м
Автомашин (Замын тоосонцорыг багтаана), бусад эх үүсвэр	2 м

(2) Цагийн өөрчлөлт (нийтлэг)

Эх үүсвэр тус бүрийн цагийн өөрчлөлтийг Хүснэгт 2.1-29-д үзүүлэв.

Хүснэгт 2.1-29 Эх үүсвэр тус бүрийн цагийн өөрчлөлт


Эх үүсвэр	Цагийн өөрчлөлт
ДЦС, УХЗ, Үйлдвэр	Сар бүрийн түлш зарцуулалтын хэмжээнээс сар тус бүрийн өөрчлөлтийг тогтоосон
Бага оврын УХЗ	Сар бүрийн түлш зарцуулалтын хэмжээнээс сар тус бүрийн өөрчлөлтийг тогтоосон
Гэрийн зуух (ханан пийшин)	Улирал бүрээр, цаг бүрээр өөрчлөлтийг тогтоосон.
Автомашин (Замын тоосонцорыг багтаана), бусад талын эх үүсвэр	Ажлын өдөр, амралтын өдөр бүрээр цагийн өөрчлөлтийг тогтоосон.
Бусад	Сар бүрээр өөрчлөлтийг тогтоосон.

(3) NO₂-ын хувиргалт

Агаарын орчны стандартад NO₂ -ыг хамруулдаг учир NOx-ын тархалтын загварчлалын дүнг NO₂-н агууламжид хувиргах шаардлагатай байдаг. Иймд бодит хэмжилтийн утгын NOx болон NO₂-оос, азотын ислийн нийт хэмжээний хэм хэмжээний зааварчилгаанд байгаа статистикийн моделийг ашиглаж NO₂-ын хувиргалтын томъёог тооцоолсон. Мониторингийн дүнгээс NOx-оос NO₂-д хувиргах томъёог Зураг 2.1-23-д үзүүлэв. Хувиргалтын томъёоны хувьд NOx-ын тархалтын загварчлалын дүнг дараах байдлаар тохируулснаар NO₂-ын тооцооллын агууламжийг гаргасан.

Гэхдээ [NO₂-ын тооцооллын агууламж]>[NOx-ын тооцооллын агууламж]-ын тохиолдолд [NO₂-ын тооцоолсон агууламж]=[NOx-ын тооцоолсон агууламж] гэж тооцож үзсэн.

$$[NO_2 \text{ тооцооллын агууламж}] = 2.9076 \times [NOx \text{ тооцооллын агууламж}]^{0.6216}$$



Зураг 2.1-23 NOx-оос NO₂-д хувиргах тооцоолол


(4) Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан модель боловсруулалт

УБ хотын хэмжээнд НАЧА болон БОХТЛ-ын агаар орчны суурин харуулаар автоматаар тасралтгүй хэмжилт явагдаж байдаг. БОХТЛ-ын суурин харуулын хувьд техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж байдаг тул хэмжилтийн утгын гажуудал бараг байхгүй, өвлийн улирлын цаг тутмын дундаж агууламжийн дүн шинжилгээнээс дүгнэхэд хэмжилтийн өгөгдөл нь итгэлцүүрийн түвшин өндөртэй гэж үзэж байна. Харин НАЧА-ны суурин харуулын тухайд төслийн судалгаанд хамруулсан хугацааны хэмжилтийн өгөгдлийн зөрүү, утгын гажуудал ихтэй байгаа юм. Иймд БОХТЛ-ийн өгөгдлийг ашиглаж тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын харьцуулалтыг хийж, тархалтын загварчлалын моделийг гаргасан болно. Тархалтын загварчлалын моделийг гаргахдаа мэргэжилтний дүгнэлтийн эх үүсвэрийн инвенторыг ашигласан.


БОХТЛ-ын суурин харуулын тооцооллын утгатай бодит хэмжилтийн утгыг харьцуулсан дүнг Зураг 2.1-24~Зураг 2.1-27-д үзүүлэв. SO_2 , CO -нь тооцооллын утгатай бодит хэмжилтийн утгын харьцаа нь бараг 1 харьцах 1 гэсэн байдалтай байгаа бөгөөд корреляцын коэффициент нь нэлээн өндөр байгаа тул маш нарийвчлал сайтай тархалтын загварчлалыг гаргаж чадсан.

Мөн PM_{10} -ын хувьд корреляцын коэффициент нь өндөр байгаа бөгөөд тооцооллын утга нь бодит хэмжилтийн утгын тал хувьтай болсон байна. PM_{10} -ын тооцооллын утга нь бодит хэмжилтийн агууламжийн тал хувь байгаагын шалтгааныг дараагийн ” 2.1.6.4 PM_{10} -ын тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын агууламжийн зөрүү “ хэсэгт тайлбарлана.


NO_2 -ын хувьд корреляцын коэффициент нь харьцангуй өндөр байна. 3 суурин харуулын тооцооллын утга нь хэтэрхий их өндөр болсон байгаа бөгөөд БОХЗТЛ-ын CLEM -2 суурин харуулын тооцооллын утгын загварт илэрхийлэгдэх дүрслэлийн байдал доогуур байна. Үүний шалтгаан нь CLEM 02 суурин харуул нь хөдөлгөөн ихтэй замын уулзварт байрласан байдаг тул автомашины хаягдал утааг хэмжих суурин харуулын төрөлд орох юм. Иймд автомашины хаягдал утааны нөлөөллийн улмаас бодит хэмжилтийн утга нь тухайн цэгийн төлөөлөх үндсэн агууламжаас их гарсан байх магадлал өндөртэй юм. Тус модель нь 1 км×1 км-ийн хавтгай дөрвөлжин талбайн дундаж агууламжийг ашиглахад тохиромжтой боловч хэдэн арван метрийн талбайг хамарсан агууламжийг илэрхийлэхэд тохиромжгүй юм. Автомашины хаягдал утааны нөлөөлөлтэй хэсэг газрыг хасвал УБ хотын хэмжээнд NO_2 -ын орчны агууламжийг тодорхойлж мэдэхэд нарийвчлал сайтай модель болсон.




Зураг 2.1-24 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (PM₁₀)



Зураг 2.1-25 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (SO₂)



Зураг 2.1-26 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (CO)



Зураг 2.1-27 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (NO₂)

2.1.6.4 PM₁₀-ын тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын агууламжийн зөрүү

PM₁₀-ын ялгарлын хэмжээг тархалтын загварчлалын дүнтэй харьцуулахад дөнгөж тал хувьтай байгааг тодорхойлж мэдсэн бөгөөд тархалтын загварчлалын дүнг бодит хэмжилтийн дүнтэй харьцуулахад ийнхүү дөнгөж хагас хувьтай байгааг дараах шалтгаанаас үүдэлтэй гэж үзэж болох юм.

- Суурин харуулын PM₁₀ нь β туяа нэвчүүлэх арга (Beta-ray attenuation method) эсвэл туяа сарниулах аргачлалыг ашигласан хэмжилтийн аргачлалыг хэрэглэсэн юм. Өвлийн улирлийн хэмжилтэд УБ хотын -30 ~ -40 температурт буурах нөхцөлд хөлдсөн агаар дахь чийгийг хэтрүүлэн хэмжиж, бодит агууламжаас хэт их гарсан байх магадлалтай юм.
- Агаарт ялгарсан бохирдуулах бодис (анхдагч тоосонцор) нь урвалд орж үүсмэл тоосонцор болдог ба PM₁₀-ын тархалтын загварчлалын модельд үүсмэл тоосонцорыг харгалзан оруулаагүй болно. Үүсмэл тоосонцорт хүхрийн нэгдэл (сульфат), азотын нэгдэл (нитрат, аммони), хлорын нэгдэл (хлорид) болон нүүрстөрөгчийн нэгдэл (органик бодис) гэсэн 4 төрөл байдаг. Ялангуяа УБ хотод нүүрсний шаталтаас хүхрийн ислүүд (SO_x) болон органик бодисын ялгарал их байдаг ба үүсмэл тоосонцор их хэмжээгээр үүсч бий болдог. Иймээс PM₁₀-ын бодит хэмжилтийн утга нь анхдагч тоосонцор гэж үзэж байгаа эх үүсвэрээс баримжаалан тооцоолсон тооцооллын утгаас өндөр гарсан байх магадлалтай юм.
- PM₁₀ -д түлшний шаталтаас үүдэлтэй ялгарлаас гадна үнсэн сангаас хийсэх тоосонцор, автозамаас бужигнах тоос шороог хамруулсан болно. Шаталтаас бусад тоосонцор, тоос шорооны ялгарлын коэффициент нь маш өргөн хүрээг хамардаг тул ямар, аль коэффициентийг ашиглахаас шалтгаалан ялгарлын хэмжээнд ихээхэн зөрүү ялгаа үүсдэг. Мөн коэффициентийн нарийвчлал нь хангалтгүй байдаг.
- Шаталтын төрлөөс бусад байдлаар PM₁₀ -ыг үүсгэж ялгаруулж байгаа эх үүсвэр байгаа.
- Үйлдвэр зэргийн ялгарлын хэмжээг тодорхойж мэдэж чадаагүй байгаа зүйл бий. Гэвч ихэнх тоосгоны үйлдвэр, асбелтын үйлдвэр нь зуны улиралд ажилладаг тул зөвхөн өвлийн улиралд ажиллаж байгаа үйлдвэрийг хамруулах болно. Иймээс үйлдвэрийн нөлөөлөл нь бусад хүчин зүйлтэй харьцуулахад нөлөөлөл нь бага байх магадлалтай юм.

PM₁₀-ын ялгарлын хэмжээний баримжаалсан тооцоололд ашигласан ялгарлын коэффициент нь тус төслийн 2 дахь дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах судалгааны хүрээнд хэмжигдсэн нүүрс 5.4 кг/тонн, түлээ 3.82 кг/тонн-ыг ашигласан. Дэлхийн банкны “Агаарын мониторинг, агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаарх суур судалгаа” (AMHIV)ны хувьд гэрийн зуухны ялгарлын коэффициентыг 16 кг/тонн, түлээ 18.5кг/тонн гэж ашигласан байгаа. ЕМЕР/ЕЕА⁴-ын ялгарлын коэффициент (380гр/ГЖ) болон нүүрсний дулааны хэмжээ² (13.4ГЖ/тонн) -ээс тооцсон PM₁₀-ын ялгарлын коэффициент 5.09 кг/тонн-той харьцуулсан ч Дэлхийн банк AMHIV-ны ялгарлын коэффициент илэрхий өндөр байгаа нь тодорхой байна. Одоогийн шатанд Дэлхийн банк AMHIV-ны гэрийн зуухны ялгарлын өндөр коэффициентыг тайлбарлаж чадах үндэслэл байхгүй байна.

PM нь БО-ны стандартын утгаас доогуур болгох арга хэмжээг сонгоход, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын моделийг сайжруулах шаардлагатай юм. Шинээр одоо инвенторт хамруулж чадаагүй байгаа агаар бохирдуулах эх үүсвэрийг хайж тогтоох, PM-ын найрлагын дүн шинжилгээ,

⁴ Small Single household scale, capacity<=50kWth boiler

Tier 2 emission factors for source category boiler burning solid fuel (except biomass)

<http://www.eea.europa.eu/publications/emep-eea-emission-inventory-guidebook-2009/part-b-sectoral-guidance-chapters/1-energy/1-a-combustion/1-a-4-small-combustion-tfeip-endorsed-draft.pdf>


⁴ ДЦС 4-ын нүүрсний найрлагын шинжилгээний дүн (3200kcal/kg)-д үндэслэн суурилуулсан.

2догч үүсмэл моделийг гаргахад шаардлагатай цаг уурын өгөгдөл зэргийг хэмжиж, РМ нь агууламж өндөртэй байгаагын шалтгааныг тодруулах шаардлагатай байна. Мөн үүсмэл 2догч шинжтэй бодисын ялгарлыг багасгах, ялангуяа SO_x-ын ялгарлын хэмжээг ихээр бууруулах аргын талаар судлах нь зүйтэй юм.


2.1.7 Тархалтын загварчлалын дүн

2.1.7.1 Тархалтын загварчлалын дүн


Хамруулсан хугацаа (2010 оны 11 сараас 2011 оны 2 сар хүртэл)-н дахь SO₂, РМ₁₀, СО болон NO₂-ын тархалтын загварчлалын дүнг Зураг 2.1-28~Зураг 2.1-31-д үзүүлэв. SO₂ болон РМ₁₀-ын хувьд Энх тайвны өргөн чөлөөнөөс хойд талын гэр хорооллын нутаг дэвсгэрт агууламж хамгийн өндөр байгаа бөгөөд бараг ижил хэмжээгээр тархсан байна. Гэр хорооллын нутаг дэвсгэрт өндөр агууламжтай байгаа нь ялгарлын өндөр газраас 5 м хүрэхгүй нам дор байгаагаас орчны агууламжид хүчтэй нөлөөлж байна гэж үзэж байна. СО нь SO₂ болон РМ₁₀-тай төстэй тархсан байгаа бөгөөд ДЦС-ын ялгарлын нөлөөлөл багатай тул ерөнхийдөө агууламжийн тархалтын хүрээ нарийссан байна. NO₂ нь хөдөлгөөний эрчим ихтэй замын уулзвар орчимд агууламж өндөртэй гарч байна. Бусад хугацааны тархалтын загварчлалын дүнг Хавсралт материал 2.1-14-д, УХЗ-ны тархалтын загварчлалын дүнг Хавсралт материал 2.1-15-д тус тус үзүүлэв.




Зураг 2.1-28 SO₂-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-29 PM₁₀-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-30 СО-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-31 NO₂-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)

2.1.7.2 Агаар орчны суурин харуулын тооцооллын агууламж болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламж

2010 оны агаар орчны суурин харуул (НАЧА, БОХЗТЛ) болон УХЗ-ны орчны хамгийн өндөр агууламж бүхий газар дах бохирдуулах эх үүсвэр тус бүрээр тооцоолсон агууламжийг Хүснэгт 2.1-30-д үзүүлэв. Тооцоолсон агууламжийг 100% гэж үзэхэд тухайн газар болгоны эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээг Зураг 2.1-32~Зураг 2.1-35 –д үзүүлэв. Мөн эх үүсвэрийн төрлөөр өмнө болон хойд зүгээр хөндлөн огтолж үзүүлсэн бохирдуулах бодис тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг Зураг 2.1-36~Зураг 2.1-39- д үзүүлэв.

Тус тооцооллын агууламж нь 4 сарын (11 сараас 2 сар) хугацааны дундаж утга юм. Орчны агаарын стандарт (MNS 4585:2007) ын дундажилсан цаг нь өөр бөгөөд тус стандарт нь агаарын бохирдлын түвшинг тогтоох зорилготой болохоор стандартын утгыг ч зурагт үзүүлсэн болно.

Энэ зургаас агаар бохирдуулах бодис тус бүрээр эзлэх нөлөөллийн агууламжийг бууруулах шаардлагатай эх үүсвэрийн төрөл, стандартаас хэтэрсэн байдлыг мэдэж болох юм. Тус техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулсан инвентор, тархалтын загварчлалын техникийн гарын авлагыг ашиглавал төрөөс авч хэрэгжүүлэх бодлогыг тогтоож шийдвэрлэхдээ тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг тооцоолж гаргаснаар үр дүн сайтай бодлого, арга хэмжээг сонгох боломжтой болох юм. Мөн тус төслөөс ялгарлын бууруулахад үр дүнтэй гэж үзэж буй хэрэгжүүлэх арга хэмжээний санал болон УБ хот болон МУ-ын хэмжээнд судлагдаж буй төрийн гол гол бодлогоос сонгож, ялгарлын бууралтын үр дүнтэй эзлэх нөлөөллийн агууламжийг бууруулах үр дүнг үнэлэх талаар жишээ гаргаж үзүүлэв. (2.5.9 харах)

(1) SO₂

SO₂-ын хувьд гэрийн зуух (ханын пийшин оруулсан) -ны нийт агууламжийн 70~80%-ийг эзэлж байгаа бөгөөд эзлэх нөлөөлөл хамгийн ихтэй байна. Дараа нь ДЦС орж байна. Ялгарлын хэмжээний тухайд эзлэх нөлөөллийн агууламж нь өндөр байгаа нь гэрийн зуухнаас ялгарах бохирдол нь тухайн орчиндоо тархдаг тул орчны агууламжид шууд хүчтэй нөлөөлж байгаа юм.

AQDCC-2 болон CLEM-5-д зөвхөн гэрийн зуухны эзлэх нөлөөллийн агууламж нь өдрийн дундаж стандартаас 4.5-6.5 дахин их агууламжтай байна. Гэрийн зуух (ханын пийшин оруулсан)-наас ялгарах SO₂-ын ялгарлын хэмжээг дорвитой бууруулах төрийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол агаарын чанарын стандартыг хангах боломжгүй гэж үзэж байна.

(2) PM₁₀

PM₁₀-ын хувьд тоос шорооны эзлэх нөлөөлөл хамгийн их байгаа бөгөөд дараа нь гэрийн зуух орж байна. Агаар орчны суурин харуулд УХЗ-ны эзлэх нөлөөлөл бага байгаа хэдий ч УХЗ-ны хамгийн өндөр агууламж бүхий газрын эзлэх нөлөөлөл нь харьцангуй өндөр байна.

Гэвч PM₁₀-ын тооцооллын утга нь бодит хэмжилтийн утгын тал хувьд л хүрч байгааг тайлбарлаж чадахгүй байгаа. PM₁₀-ын тооцооллын утга нь хэтэрхий бага гарсаны учир шалтгааныг тодруулахын тулд УБ хотын гол цэг газарт High volume sampler-ийг суурилуулан PM₁₀-ыг хэмжиж, түүний найрлагын дүн шинжилгээг хийх юм. Ингээд эх үүсвэр, найрлагын шинжилгээний дүн болон СМВ арга зэргийг ашиглан гаргасан тархалтын загварчлалын дүнгийн харьцаа холбооноос УБ хотын PM₁₀ ялгаруулах эх үүсвэр тус бүрээр эзлэх нөлөөллийн хэмжээг үнэлж, арга хэмжээний санал боловсруулах ажилтай уялдуулан холбох шаардлагатай юм.

AQDCC-2 болон CLEM-5-д зөвхөн гэрийн зуух болон автозамыг тоос шорооны эзлэх нөлөөллийн агууламж нь өдрийн дундаж стандартаас 2 дахин их агууламжтай байна. PM_{10} -ын тооцооллын утга нь хэтэрхий бага гарсан хэдий ч үнэндээ 4 дахин их нөлөөлөлтэй байх магадлалтай юм. Гэрийн зуух (ханын пийшин оруулсан), автозамын тоос шорооноос ялгарах PM_{10} -ын ялгарлын хэмжээг дорвитой бууруулах бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол агаарын чанарын стандартыг хангах боломжгүй гэж үзэж байна.

(3) CO

CO –ын хувьд гэрийн зуухны эзлэх нөлөөлөл хамгийн ихтэй бөгөөд дараа нь автозам орж байна.

Гэвч ялгарлын хэмжээ нь БО-ны стандартаас доогуур байгаа учраас CO-ын ялгарлыг бууруулах шаардлагагүй гэж хэлж болох юм.

(4) NO₂

NO₂ -ын хувьд автозам болон туслах замын эзлэх нөлөөлөл их байна.

Автомашинны эзлэх нөлөөллийн агууламж нь өдрийн дундаж стандартаас хэтэрсэн газрууд байгаа бөгөөд нийт агууламж нь өдрийн дундаж стандартаас 1.5 дахин хэтэрсэн байна. Зураг 2.1-27-д үзүүлсэнчлэн CLEM-2-т тооцооллын агууламжаас 1.5 дахин орчим их агууламжтай байгаа тул автомашинаас ялгарах NO_x-ын ялгарлын хэмжээг талаас дээш хувиар багасгахгүй бол агаарын чанарын стандартыг хангахгүй гэж үзэж байна.

Хүснэгт 2.1-30 Суурин харуул болон УХЗ-ны хамгийн өндөр агууламж бүхий газрын эх үүсвэр тус бүрээр тооцоолсон агууламж (2010 он)


SO ₂													
Суурин харуул/ хэмжээний цэг	Тооцооллын утга							Бодит хэмжээний утга	Тооцооллын утга-Бодит хэмжээний	Хүчинтэй өгөгдлийн тоо	Хүчинтэй өгөгдлийн хувь		
	ДЦС	УХЗ	Бага оврын УХЗ	Гэрийн зуух	Автозам	Нарийн зам	Нийт						
AQDCC1	3.94	0.52	1.33	34.16	2.17	0.88	43	98.75	-55.75	2784	96.67%		
AQDCC2	2.89	1.4	2.73	117.15	1.21	0.44	125.82	84.77	41.05	1939	67.33%		
AQDCC3	2.18	1.21	1.81	49.19	2	1.31	57.7	55.43	2.27	2055	71.35%		
AQDCC4	2.86	0.46	0.44	29.58	0.31	0.05	33.7	28.33	5.37	62	2.15%		
НОВ_Max	1.08	6.81	3.82	77.71	0.47	0.25	90.14		90.14		0.00%		
CLEM01	6.17	0.36	0.55	16.4	1.11	0.44	25.03	43.86	-18.83	1847	64.13%		
CLEM02	3.94	0.52	1.33	34.16	2.17	0.88	43	52.70	-9.70	2735	94.97%		
CLEM03	4.23	0.48	1.67	73.88	1.07	0.43	81.76		81.76		0.00%		
CLEM04	2.18	1.21	1.81	49.19	2	1.31	57.7		57.70	0	0.00%		
CLEM05	2.27	1.45	2.62	87.57	2.12	1.05	97.08	105.73	-8.65	2852	99.03%		
CLEM06	1.45	2.16	2.6	72.02	0.78	0.61	79.62		79.62		0.00%		
CLEM07	6.08	0.3	0.71	21.82	0.56	0.19	29.66	36.04	-6.38	2277	79.06%		
CLEM08								35.49	-35.49	2510	87.15%		
Корреляцын коэффициент (НАЧА-ны суу рин)											0.677		

PM10													
Суурин харуул/ хэмжээний цэг	Тооцооллын утга							Бодит хэмжээний утга	Тооцооллын утга-Бодит хэмжээний	Хүчинтэй өгөгдлийн тоо	Хүчинтэй өгөгдлийн хувь		
	ДЦС	УХЗ	Бага оврын УХЗ	Гэрийн зуух	Автозам	Нарийн зам	Нийт						
AQDCC1	5.39	0.81	0.56	40.19	1.91	0.84	85.38	0.26	135.34	182.54	-47.20	2877	99.90%
AQDCC2	4.03	1.77	1.14	139.15	1.05	0.42	62.58	0.15	210.29	327.94	-117.65	1985	68.92%
AQDCC3	2.95	1.96	0.76	57.74	1.73	1.26	90.81	0.16	157.37		157.37	0	0.00%
AQDCC4	3.95	0.52	0.18	35.20	0.36	0.04	10.39	0.47	51.11	178.43	-127.32	2877	99.90%
НОВ_Max	1.44	33.71	1.59	90.19	0.49	0.24	33.95		161.68		161.68		0.00%
CLEM01	8.31	0.56	0.23	19.23	1.16	0.42	41.09	0.54	71.54	194.06	-122.52	2495	86.63%
CLEM02	5.39	0.81	0.56	40.19	1.91	0.84	85.38	0.26	135.34	306.93	-171.59	1705	59.20%
CLEM03	6.15	0.74	0.7	86.22	1.02	0.41	56.37	0.23	151.84		151.84		0.00%
CLEM04	2.95	1.96	0.76	57.74	1.73	1.26	90.81	0.16	157.37		157.37	0	0.00%
CLEM05	3.1	2.22	1.09	102.63	1.83	1	109.73	0.14	221.74	625.90	-404.16	2797	97.12%
CLEM06	1.95	3.92	1.09	84.87	0.72	0.58	77.58	0.13	170.84		170.84		0.00%
CLEM07	8.88	0.49	0.3	25.51	0.58	0.18	24.5	0.64	61.08	273.30	-212.22	2303	79.97%
CLEM08									144.15		-144.15	2547	88.44%
Корреляцын коэффициент (НАЧА-ны суу рин)											0.748		


CO													
Суурин харуул/ хэмжээний цэг	Тооцооллын утга							Бодит хэмжээний утга	Тооцооллын утга-Бодит хэмжээний	Хүчинтэй өгөгдлийн тоо	Хүчинтэй өгөгдлийн хувь		
	ДЦС	УХЗ	Бага оврын УХЗ	Гэрийн зуух	Автозам	Нарийн зам	Нийт						
AQDCC1	3.14	3.54	1.97	500.72	315.17	104.28	928.82	2337.18	-1408.36	2876	99.86%		
AQDCC2	2.77	13.33	4.04	1661.68	170.15	52.66	1904.63	4188.66	-2284.03	670	23.26%		
AQDCC3	1.78	7.75	2.68	726.4	297.57	156.22	1192.4	988.79	203.61	2678	92.99%		
AQDCC4	3.64	2.64	0.64	416.77	22.25	5.55	451.49	894.88	-443.39	2877	99.90%		
НОВ_Max	0.9	37.54	5.65	1190.46	54.66	30.03	1319.24		1319.24		0.00%		
CLEM01	4.12	2.32	0.81	242.69	117.15	52.07	419.16	1140.10	-720.94	2325	80.73%		
CLEM02	3.14	3.54	1.97	500.72	315.17	104.28	928.82	2710.26	-1781.44	2709	94.06%		
CLEM03	5.2	3.01	2.47	1111.68	140.1	51.03	1313.49		1313.49		0.00%		
CLEM04	1.78	7.75	2.68	726.4	297.57	156.22	1192.4		1192.40	0	0.00%		
CLEM05	1.99	9.64	3.87	1299.37	298.11	124.86	1737.84	3789.71	-2051.87	2861	99.34%		
CLEM06	1.2	12.33	3.85	1050	92.46	72.18	1232.02		1232.02		0.00%		
CLEM07	7.69	1.98	1.05	326.54	59.84	22.27	419.37	1251.29	-831.92	2181	75.73%		
CLEM08								795.66	-795.66	836	29.03%		
Корреляцын коэффициент (НАЧА-ны суу рин)											0.657		

NO ₂													
Суурин харуул/ хэмжээний цэг	Тооцооллын утга							Бодит хэмжээний утга	Тооцооллын утга-Бодит хэмжээний	Хүчинтэй өгөгдлийн тоо	Хүчинтэй өгөгдлийн хувь		
	ДЦС	УХЗ	Бага оврын УХЗ	Гэрийн зуух	Автозам	Нарийн зам	Нийт						
AQDCC1	3.97	0.08	0.44	4.79	31.85	17.51	58.65		58.65		0.00%		
AQDCC2	3.03	0.20	0.90	15.58	21.96	9.07	50.74		50.74		0.00%		
AQDCC3	2.28	0.19	0.60	6.97	30.44	22.51	62.99		62.99		0.00%		
AQDCC4	3.64	0.08	0.14	3.89	6.06	0.96	14.77		14.77		0.00%		
НОВ_Max	1.18	1.24	1.26	11.66	9.56	5.18	30.08		30.08		0.00%		
CLEM01	5.97	0.06	0.18	2.33	19.62	8.97	37.13		-5.30	2420	84.03%		
CLEM02	3.97	0.08	0.44	4.79	31.85	17.51	58.65	124.73	-86.09	2773	96.28%		
CLEM03	4.49	0.08	0.55	10.79	23.21	8.79	44.91		44.91		0.00%		
CLEM04	2.28	0.19	0.60	6.97	30.44	22.51	62.99		62.99	0	0.00%		
CLEM05	2.38	0.23	0.86	12.51	31.02	19.59	66.59	65.33	1.26	2864	99.44%		
CLEM06	1.56	0.34	0.86	10.01	16.00	12.44	41.21		41.21		0.00%		
CLEM07	6.47	0.05	0.23	3.16	11.18	3.84	24.93	33.37	-8.44	1468	50.97%		
CLEM08								39.96	-39.96	1750	60.76%		
Корреляцын коэффициент (НАЧА-ны суу рин)											0.686		


Корреляцын коэффициент ороолуу




Зураг 2.1-32 SO₂-ын тооцооллын агууламжид хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээ (2010 он)




Зураг 2.1-33 PM₁₀-ын тооцооллын агууламжид хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээ (2010 он)




Зураг 2.1-34 CO-ын тооцооллын агууламжид хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээ (2010 он)




Зураг 2.1-35 NO_2 -ын тооцооллын агууламжид хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээ (2010 он)




Зураг 2.1-36 Эх үүсвэрийн төрлөөр өмнөд болон хойд зүгээр хөндлөн огтолож үзүүлсэн SO₂ -ын эзлэх нөлөөллийн агууламж (2010 он)



Зураг 2.1-37 Эх үүсвэрийн төрлөөр өмнөд болон хойд зүгээр хөндлөн огтолж үзүүлсэн PM₁₀ -ын эзлэх нөлөөллийн агууламж (2010 он)



Зураг 2.1-38 Эх үүсвэрийн төрлөөр өмнөд болон хойд зүгээр хөндлөн огтолож үзүүлсэн CO -ын эзлэх нөлөөллийн агууламж (2010 он)



Зураг 2.1-39 Эх үүсвэрийн төрлөөр өмнөд болон хойд зүгээр хөндлөн огтолж үзүүлсэн NO₂ -ын эзлэх нөлөөллийн агууламж (2010 он)

2.1.7.3 Тархалтын загварчлалын дүнгийн үнэлгээ

SO₂ болон NO₂-ын тархалтын загварчлалын дүнтэй жилийн БО-ны стандартыг харьцуулсан дүнг Хүснэгт 2.1-31-г үзүүлэв. Жилийн SO₂-ын БО-ны стандарт (10µg/m³)-тай харьцуулахад 65.55%, өдрийн дундаж SO₂-ын БО-ны стандарт (20µg/m³)-тай харьцуулахад 30.46%-ийн тооцоолсон гридээр, жилийн NO₂-ын БО-ны стандарт (30µg/m³)-тай харьцуулахад 7.56%, өдрийн дундаж NO₂-ын БО-ны стандарт (40µg/m³)-тай харьцуулахад 3.57%-иар тус тус тооцооллын гридээс хэтэрсэн байсан.

PM₁₀-ын хувьд тооцооллын утгын илэрхийлэл дүрслэлийн байдал багатай байсан болохоор байгаль орчны стандарттай харьцуулалт хийгээгүй.


Хүснэгт 2.1-31 БО-ны стандарт болон тархалтын загварчлалын дүнгийн харьцуулалт (2010 он)

Хамрагдсан бодис	Жилийн БО-ны стандартаас хэтэрсэн гридийн тоо / Нийт тооцоолсон гридын тоо (хэтэрсэн хувь)	Өдрийн дундаж БО-ны стандартаас хэтэрсэн гридийн тоо / Нийт тооцоолсон гридын тоо (хэтэрсэн хувь)
SO ₂	624/952 (65.55%)	290/952 (30.46%)
NO ₂	72/952 (7.56%)	34/952 (3.57%)


2.1.7.4 2010 он болон 2011 оны тархалтын загварчлалын дүнгийн харьцуулалт

2010 оноос 2011 онд ялгарлын эх үүсвэр (гэр хорооллын айл өрхийн тоо, автомашин зэрэг) нэмэгдсэн бөгөөд үүнтэй холбогдуулан АБ-ыг бууруулахад чиглэсэн олон чиглэлийн төрийн бодлогыг хэрэгжүүлсэн.

2010 он болон 2011 онд УБ хотын хэмжээнд PM₁₀-ын хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг харьцуулсан дүнг Зураг 2.1-40 ~ Зураг 2.1-41-д үзүүлэв. Ихэнх хэмжилтийн цэгт 2010 оноос 2011 онд онцын өөрчлөлт гараагүй байна. Харин УХЗ-ны хувьд хамгийн өндөр агууламжтай гарсан цэгт 2010 оноос 2011 онд УХЗ-ны эзлэх нөлөөллийн агууламж ихээхэн буурсан байгаа бөгөөд энэ нь тухайн орчны УХЗ нь PM-ын ялгарлын хэмжээ багатай зуухыг суурилуулсантай холбоотой гэж үзэж байна.



Зураг 2.1-40 2010 он болон 2011 онд хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрт PM₁₀-ын эзлэх нөлөөллийн хэмжээний харьцуулсан дүн



Зураг 2.1-41 2010 он болон 2011 онд хэмжилтийн цэг болон эх үүсвэр тус бүрт PM₁₀-ын эзлэх нөлөөллийн хэмжээний харьцуулсан дүн